

Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн тухай танилцуулга

2011 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр

Завхан аймаг

№	Нэр, огноо, дугаар	Заалтын дугаар, агуулга	Хэрэгжилтийн явц	Хувь
Нэг. ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ				
Санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалт				
1	Дунд хугацааны төсвийн төлөвлөлтийг сайжруулах зарим арга хэмжээний тухай 2008.04.02 дугаар 126	2.Монгол Улсын дунд хугацааны буюу 2009-2011 оны төсвийн төслийг Үндэсний хөгжлийн цогц бодлого, Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилт, тухайн салбарын мастер төлөвлөгөөнд тодорхойлсон зорилго, үр дүнг хангахад чиглүүлэн бүтээгдэхүүн хөтөлбөрт түүнийг санхүүжилтээр төлөвлөлтийн зарчмаар боловсруулах арга хэмжээ авч ажиллахыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгосугай.	2009-2011 оны төсвийн төслийг хөтөлбөрт суурилсан төлөвлөлтийн зарчмаар боловсруулах тухай Улаанбаатар хотод зохион байгуулагдсан санхүүгийн ажилтны сургалт семинарт холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулж, төсвийн шинэчлэлийг хэрэгжүүлж, 2009, 2010 оны төсөв, 2011-2012 оны төсвийн төсөөллийг энэ зарчмаар боловсрууллаа. 2011 оны төсвийг Аймгийн ИТХ-аар оруулж батлууллаа.	90.0
2	Төсвийн зардлыг хэмнэх, зарим арга хэмжээний тухай 2008.04.02 дугаар 128	2а.Сургууль эмнэлгээс бусад төсөвт байгууллагуудад эд хөрөнгө худалдан авах зардлыг 50 хувиар, урсгал засварын зардлыг 20 хувиар бууруулах	Төсөвт байгууллагуудад 2010 онд эд хөрөнгө худалдан авах зардал төсөвт тусгагдаагүй бөгөөд аймгийн ИТХ-аас хөрөнгө бэлтгэх зөвшөөрлийг олгоогүй болно. Урсгал засварын зардал буурч байна.	70,0
		2б.Төв суурин газрын төсвийн байгууллагуудад халаалтын хэмнэлтийн горим сонгох, цахилгаан усыг хэмнэж, ариг гамтай зарцуулах	Төсвийн байгууллагуудын гэрэл, цахилгаан, цэвэр бохир усны зардалд хяналт тавьж ажилласнаар 12 сарын 15-ны байдлаар гэрэл цахилгаан 42.6 сая төгрөг, цэвэр бохир ус 20.7 сая төгрөгөөр тус тус хэмнэгдлээ.	100.0
		2в.Гадаад албан томилолт, гадаад зочны зардлыг 30 хувиар бууруулах, УИХ-ын болон орон нутгийн хурлын сонгуулиуд болох гэж байгаатай холбогдуулан төрийн захиргааны байгууллагын дотоод албан томилолтыг багасгах	Гадаад албан томилолт болон гадаад арга хэмжээний зардалд төсвөөс хөрөнгө зарцуулаагүй бөгөөд шаардлагатай зардлыг “Эрчимтэй хөгжлийн Завхан сан”-гаас гаргасан.	100.0
		2г.Электрон шуудан, интернетийн холбоо ашиглах замаар шуудан холбоо, бичиг хэргийн зардлыг 10-аас доошгүй хувиар хэмнэх	Электрон шуудан, интернетийн холбоо ашиглаж байна. Холбоо, бичиг хэргийн зардал хэтрээгүй болно.	100.0
		2д.Дүрэмт хувцсыг гамтай хэрэглэж, эдэлгээний хугацааг уртасгах замаар хэмнэлт бий болгох, тодорхой салбаруудад дүрэмт хувцас хэрэглэхээс татгалзах, хугацааг түр хойшлуулах	Аймгийн Цагдаагийн газар, Онцгой байдлын хэлтэс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Татварын хэлтэс зэрэг байгууллагууд дүрэмт хувцас хэрэглэж, бусад байгууллагууд дүрэмт хувцас хэрэглээгүй байна. Нийгмийн даатгалын хэлтсийн ажилтнуудын дүрэмт хувцасны зардлыг 2009-2010 онд төсөвт тусгаагүй болно.	90.0

3	Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай 2008.04.23 дугаар 148	2.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт бий болсон хөрөнгийн үнэ, өртөг, тоо хэмжээ, эзэмших этгээдийн талаархи саналаа бусад холбогдох материалын хамт тухай бүр Төрийн өмчийн хороонд ирүүлж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч, ерөнхий менежер нарт даалгасугай.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн судалгааг гаргаж, улсын комиссын актыг үндэслэн данс бүртгэлд тусгаж, орлого авсныг хянаж, хөрөнгийн бүртгэлийг шинэчилж, аймгийн Засаг даргын зөвлөл, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж, дүн мэдээг хугацаанд нь Төрийн өмчийн хороонд хүргүүлж байна. Хөрөнгийн дахин үнэлгээний дүнг тооллогын материалын хамт Төрийн өмчийн хороонд хүргүүлсэн.	90.0
4	Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарыг хувьчлах өөрчлөн байгуулах чиглэл батлах тухай 2008.05.14 дугаар 182	2."Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарыг хувьчлах өөрчлөн байгуулах чиглэл"-д тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж дүнг Засгийн газарт жил бүр танилцуулж байхыгаймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	"Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарыг хувьчлах өөрчлөн байгуулах чиглэл"-ийн дагуу санал боловсруулж, төлөвлөгөө гарган ээлж дараатай шийдвэрлэж байна. 2009 онд нийтийн аж ахуйн үйлчилгээний "Амь-Ус" трейд компаний халаалтын 1 дүгээр зуухыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 36 дугаар тогтоолоор менежментийн гэрээгээр хувьчлаад байна.	70.0
5	Чиглэл батлах тухай 2008.05.14 дугаар 184	1.Монгол Улсыг хөгжүүлэх сангаас улсын эдийн Засгийн чадавхийг дээшлүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг төлөвлөхөд 2009-2015 онд баримтлах чиглэлийг хавсралтын ёсоор баталсугай.	Хөрөнгө оруулалтын санхүүжилтийг төлөвлөхдөө энэ чиглэлийг баримталж, тэргүүлэх салбарын хэмжээнд оруулах хөрөнгийн талаарх саналаа хүргүүлсэн боловч 2009, 2010 онд хөрөнгө тусгагдаагүй.	70.0
6	Төрийн өмчит хувьцаат компани байгуулах тухай 2008.06.03 дугаар 233	3."Алтай-Улиастайн дамжуулах сүлжээ" "Тайшир усан цахилгаан станц" "Гуулин усан цахилгаан станц" "Богдын гол усан цахилгаан станц" "Тосонцэнгэл усан цахилгаан станц" "Завханмандал усан цахилгаан станц" "Цэцэн-Уул усан цахилгаан станц" хязгаарлагдмал хариуцлагатай компаниудыг шинээр үүсгэн байгуулж, тэдгээрийг "Алтай-Улиастайн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн охин компаний хэлбэрээр ажиллуулсугай.	"Алтай-Улиастайн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компани байгуулагдан ажиллаж байна. Богдын гол, Тосонцэнгэл, Цэцэн-Уул, Завханмандалын усан цахилгаан станцуудыг дотоод шугам сүлжээний хамт энэ компаний мэдэлд шилжүүлж, үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байна.	90.0
7	Дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн үе шатыг батлах тухай 2008.06.18 дугаар 256	3.Дунд хугацааны төсөв, төсвийн ерөнхийлөн захирагчийн зарлагын хязгаар боловсруулахад шаардагдах төсвийн баримт бичиг, үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг тогтоосон хугацаанд чанартай боловсруулан эрх бүхий байгууллагад хүргүүлж байхыг төсвийн ерөнхийлөн 4захирагч, төсвийн байгууллагын ерөнхий менежерүүдэд үүрэг болгосугай.	Дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн баримт бичгүүдийг энэ тогтоолоор батлагдсан хугацаанд боловсруулж холбогдох газруудад хүргүүлж байна. 2011-2012 оны төсвийн төсөөлөл, аймгийн 2010, 2011 оны төсвийг Сангийн Яаманд хүргүүлсэн.	90.0

8	Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2008.12.03 дугаар 50	4.Монгол Улсын геодезийн цэг, тэмдэгтийн нарийвчилсан тооллогын ажлыг 2010 оны эхний хагас жилд багтаан хийж дуусган ашиглалт, хадгалалт, хамгаалалтад нь хяналт тавьж ажиллахыг ...бүх шатны Засаг дарга нарт даалгасугай.	2009 онд тус аймгийн 24 сумын хот суурин болон тариалангийн газрын кадастрын зургийг хийж, гүйцэтгэн сум бүрт 6-7 геодезийн цэг тэмдэгтийн суулган Засаг дарга, газрын даамал нарт хүлээлгэж өгсөн. 2010 онд нарийвчилсан тооллогыг зохион байгуулах ажлын хэсгийг бүх сумдад гарган геодезийн цэг, тэмдэгтийг хүлээлгэн өгсөн.	100.0
		8.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эзэмшил газар болон баталгаажуулсан хэмжээг тогтоосон шийдвэрт өөрчлөлт оруулах тухай бүр Төрийн өмчийн хороотой урьдчилан зөвшилцөж байхыг аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт үүрэг чиглэл өгч ажиллаж байна. Одоогоор баталгаажуулсан газрын хэмжээг өөрчлөх санал гараагүй байна.	90.0
		9.Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогоор эд хөрөнгө дутагдуулсан хуулийн этгээдийн удирдлага, холбогдох ажилтанд хариуцлага тооцох, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх арга хэмжээ авч, дүнг Төрийн өмчийн хороонд хүргүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	2008 оны төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн тооллогоор аймгийн хэмжээнд 42.8 сая төгрөгийн эд хөрөнгө данс бүртгэлээс дутсан дүнг гарсан. Үүнд: Дөрвөлжин сумын Хомын бага сургуулийн 26.7 сая төгрөгийн барилга, хүн эмнэлгийн 5.3 сая төгрөгийн барилга, Шилүүстэй сумын Хүн эмнэлгийн 6.5 сая төгрөгийн УАЗ-469 маркийн автомашин, 11 жилийн сургуулийн 0.7 сая төгрөгийн махны зoorь, Эрдэнэхайрхан сумын ЗДТГ-ын 63 толгой мал орж байна. Үүнээс Дөрвөлжин сумын Хомын бага сургуулийн болон хүн эмнэлгийн барилгын, Шилүүстэй сумын 11 жилийн сургуулийн махны зoorийн асуудал бүрэн шийдвэрлэгдсэн. 2010 оны 05 сарын 20 нд Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар орон нутгийн өмчийн эд, хөрөнгийн тооллогын дүнг оруулж баталгаажуулан төрийн өмчийн хороонд хүргүүлээ	90.0
9	Монгол Улсын төсвийн орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээний ангилалыг батлах тухай 2009.04.08 дугаар 99	2.Үйл ажиллагааны зардлын эх үүсвэр дутагдсан тохиолдолд өр үүсгэхгүй байх зарчим баримтлан төсвийн зарлагын арга хэмжээний ангиллын дагуу бусад арга хэмжээний зардлаас /үүнд аюулгүй байдлыг хамгаалах, стратегийн болон онцгой байдлын нөөцийн зардал хамаарахгүй/ нийт 10 хүртэл хувийг "Байгууллагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ"-ний урсгал зардалд шилжүүлэх эрхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт олгосугай.	2010 оны 12 дугаар сарын 1-ний гүйцэтгэлээр аймгийн төсөвт байгууллагууд 594.2 сая төгрөгийн өглөгтэй, 72.9 сая төгрөгийн авлагатай байна. Төсвийн зарлагын ангилалыг заасан хэмжээнээс хэтрүүлж шилжүүлээгүй	70.0

10	Зарлагын хязгаар батлах тухай 2009.07.22 дугаар 220	1.Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн 2010 оны төсвийн зарлагын хязгаар болон 2011-2012 оны зарлагын хязгаарын төсөөллийг хавсралт ёсоор баталсугай. /Завхан: 2010 онд 4174.4 сая төг, 2011 онд 5.074.5 сая төг, 2012 онд 5,793.1 сая төг/	Төсвийн зарлагын хязгаарыг баримталж, аймгийн 2010 оны төсвийн төсөл, 2011-2012 төсвийн төсөөллийг боловсруулсан.	90.0
11	Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө бэлтгэх ажлыг журамлах тухай 2009.07.29 дугаар 234	2.Төрийн өмчит хуулийн этгээд нь дараа онд хэрэгцээтэй байгаа үндсэн хөрөнгийн нэр төрөл, тоо хэмжээ, тэдгээрийг худалдан авахад шаардагдах зардлын төсвийн төслийн саналыг тухайн жилийн 6 дугаар сарын 1-ний дотор Төрийн өмчийн хороонд ирүүлж байхаар тогтоосугай.	Тогтоолыг төрийн өмчит байгууллагуудад хувилан хүргүүлж , үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.	90.0
12	Төрийн албан хаагчид болон иргэдийг орон сууцаар хангах арга хэмжээний тухай 2009.10.14 дугаар 321	2.Барьж дуусган улсын комисст хүлээлгэж өгсөн арилжааны банкны зээлийн барьцаанд байгаа орон сууцыг м. кв талбайн үнийг 650.0 /зургаан зуун тавин/ мянган төгрөгөөс хямд байх зарчим баримтлан “Орон сууцны санхүүжилтийн корпораци” ХХК-иар дамжуулан төрийн албан хаагчдад урт хугацаатай зээлээр олгохыг...Засаг дарга нарт даалгасугай.	2.Улиастай суманд баригдсан 30 айлын орон сууцыг 2009 онд, 20 айлын орон сууцыг 2010 онд улсын комисст хүлээлгэн өгсөн.” Орон сууцны санхүүжилтийн корпораци” ХХК-иар дамжуулан Хадгаламж банк урт хугацаатай зээлээр олгож байна.Метр кв талбайн үнийг 565,0 /таван зуун жаран таван/ мянган төгрөгөөр зээлийн гэрээ хийгдэж байна	100.0
16	Төсвийн хязгаар батлах тухай 2010.07.20 дугаар 194	1. Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн 2011 оны төсвийн хязгаар болон 2012-2013 оны төсвийн хязгаарын төсөөллийг хавсралт ёсоор баталсугай.	2010 оны 08 сард төсвийн төслөө боловсруулж Сангийн Яаманд хүргүүлсэн болно.	100,0
		2.Батлагдсан төсвийн хязгаарт багтаан 2011 оны төсвөө боловсруулахыг Төсвийн Ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Батлагдсан төсвийн хязгаарт багтаан төсвөө боловсруулсан болно.	100,0
19	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах нийтлэг журам батлах тухай 2010.06.19 дугаар 123	1. “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах нийтлэг журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.	“Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах нийтлэг журам”-ыг хяналтанд авч, мөрдөн ажиллаж байна.	100,0
		2.Эрхлэх ажлынхаа хүрээний хөрөнгө оруулалтын төслийн судалгаа, үр ашгийн тооцоог үнэлж, ач холбогдолоор нь эрэмбэлэн жил бүрийн 2 сарын 5-ны дотор Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороонд хүргүүлж байхыг төсвийн Ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Хөрөнгө оруулалтын төслийн судалгаа, үр ашгийн тооцоог үнэлж, ач холбогдолоор нь эрэмбэлэн Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороонд хүргүүлэхэд бэлэн болоод байна.	70,0
		Орон нутгийн хөгжлийн төлөвлөлт		
20	Хөгжлийн индексийн тухай 2010.04.07 дугаар 88	2.Хөгжлийн индексийн үр дүнг салбарын болон орон нутгийн хөгжлийн төлөвлөлтөд ашиглаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгосугай.	Тогтоолоор батлагдсан хөгжлийн индекс тооцох аргачлалыг холбогдох байгууллагуудад хүргүүлэн орон нутгийн хөгжлийн төлөвлөлтөнд ашиглаж байна.	100,0
		Хөдөө аж ахуй		

21	Төлөвлөгөө батлах тухай 2009.07.08 дугаар 208	2.Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын эхний үе шат /2009-2015 он/-нд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд заасан арга хэмжээ, санхүүгийн эх үүсвэрийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай хамтарч, төлөвлөгөөнд тусгагдсан орон нутагтай холбоотой заалтуудыг хэрэгжүүлэх талаар сумдын Засаг дарга, ХАА-н ажилтан, мэргэжилтэн, багийн Засаг дарга, малчдын төлөөлөл 208 хүний бүрэлдэхүүнтэй сургалт зохион байгуулж, малчдад сурталчилж байна	70.0
22	Өвөлжилтийн байдал хүндэрч байгаатай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2010.01.11 дугаар 7	5.Улсын нөөцөөс хөнгөлттэй үнээр худалдах өвс, тэжээлийг зориулалт бусаар зарцуулах, дамлан худалдаалах зөрчил гаргуулахгүй байх арга хэмжээ авч ажиллахыг холбогдох аймгийн Засаг дарга нарт даалгасугай. Завхан: өвс 700 тн, тэжээл 600 тн, тээврийн зардал 5,0 сая төг, нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлж байгаа автомашины шатахууны зардал 5,0 сая төг, зам даваа онгойлгох зардал 13,5 сая төгрөг	Улсын нөөцийн 5 цэгээс өвөлжилтийн байдал, өвс тэжээлийн хэрэгцээг тооцож, 24 суманд 2 удаагийн хуваарилалтаар өвс 700 тн, тэжээл 400 тн, 5.0 сая төгрөг, аймгийн зам засвар арчлалтын компанид 13.5 сая төгрөг, Онцгой комисст 1.9 сая төгрөг, ИТХ-д 3.1 сая төгрөг тус тус олгосон.	100,0
23	Хурдан морины шигшмэл болон бүсийн уралдааны 2010 оны хуваарийг тогтоох тухай 2010.1.20 дугаар 16	2...хурдан морьдын уралдааныг заагдсан хугацаанд нь зохион байгуулалт сайтай, хурдан морины уралдааны дүрмийн дагуу явуулахыг ...аймаг нийслэлийн Засаг дарга нар, Монголын морин спорт, уяачдын төв болон салбар холбоодод даалгасугай. /Баруун бүсийн бүсийн зуны уралдааныг 2010 оны 7 дугаар сарын 28-29-ний өдөр Говь-Алтай аймагт болно./	Аймгийн Морин спорт, уяачдын холбооны удирдлагуудад танилцуулж, уралдаанд оролцох ажлыг зохион байгуулах комиссыг байгуулан энэхүү арга хэмжээнд 5 сумын 15 уяачыг оролцууллаа.	100,0
24	Ургамалын үр, үрслэг, суулгац нэвтрүүлэх, үржлийн мал, түүхий мах, дайвар бүтээгдэхүүн экспортлох боомтын тухай 2010.1.27 дугаар 22	2.Улсын хилийн дараахь боомтуудаар үржлийн мал экспортлохыг зөвшөөрсүгэй. Үүнд:--Завхан аймгийн Арцсуурь /2011 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр хүртэл/	Арц суурийн боомтоор мал гаргах бэлтгэл ажлыг хангаж, хил дээр лаборатори байгуулан ажиллуулж, 2009 онд 2350 малд 5 төрлийн шинжилгээ хийлгэсэн боловч ОХУ хүлээж авахаас татгалзсан.	100,0
25	"Улсын сайн малчин"...шагнал олгох тухай 2010.01.27 дугаар 24	1.Болзлын шаардлага хангаж, өндөр амжилт гаргасан: ...-Завхан аймгийн Сантмаргац сумын Баян-Улаан багийн малчин Өнөбаярын Хайчаа...нарыг "Улсын сайн малчин"-аар шалгаруулсугай.	Шагналыг хүндэтгэлтэй гардуулан өгч, хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр сурталчлан, залуу малчдад арга туршлагыг эзэмшүүлэх, зөвлөгөө өгүүлэх арга хэмжээ авч байна.	100,0
26	2009-2010 оны зудын хохирлыг арилгах зарим арга хэмжээний тухай 2010,06,02 дугаар 137	1.Мал аж ахуйн салбарт 2009-2010 оны өвөл, хаврын улиралд тохиолдсон зудын хохирлыг арилгах арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.	Мал аж ахуйн салбарт 2009-2010 оны өвөл, хаврын улиралд тохиолдсон зудын хохирлыг арилгах арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг баталсан тогтоолыг хяналтанд авлаа.	100,0

		2.Дотоод, гадаадын төсөл, хөтөлбөр болон гадаад орон, олон улсын байгууллагын хандив, тусламж, зээлийн эх үүсвэрээр малчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, тэдэнд эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх, амьжиргааны эх үүсвэргүй болсон малчдыг малжуулах, орон нутагт жижиг дунд үйлдвэр, үйлчилгээний салбарыг хөгжүүлэх, бичил уурхайд зохион байгуулалттайгаар ажиллуулах зэргээр тухайн орон нутаг бүрт тохирсон ажлын байр бий болгох арга хэмжээ авахыг Сангийн Сайд С.Баярцогт, Гадаад харилцааны Сайд Г.Занданшатар, Эрүүл мэндийн Сайд С.Ламбаа, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн Сайд Т.Ганди, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн Сайд Т.Бадамжунай, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Малгүй болсон өрхүүдийг малжуулах талаар 24 сумын 86 багийн иргэдтэй уулзалт зохион байгуулж, улсын хөрөнгө оруулалт болон халамж үйлчилгээний журмаар 309 малчныг малжуулах арга хэмжээнд хамрууллаа.	100,0
		3.1. Орон нутгаас төв суурин газарт шилжиж ирсэн иргэдэд хашааны газар олгох, хөдөлмөр эрхлэх болон халамжийн чиглэлээр тодорхой дэмжлэг үзүүлэх	Хөдөөний багаас аймгийн төвд гэр бүлээрээ шилжин ирж суурьшсан 12 өрхөд хашааны газар олгосон байна.	100,0
		3.2. Малгүй болсон малчин өрхийг малжуулах, бусад салбарт мэргэшүүлэн шилжүүлэх ажлыг сумдын удирдлагатай хамтран зохион байгуулах	Улсын хөрөнгө оруулалтаар 294, халамж үйлчилгээний чиглэлээр 15 нийт 309 өрхийг малжууллаа.	100,0
		3.3.Олон мал бүхий малчдын малыг түрээсээр маллуулах, гэрээгээр мал өгөх зэргээр малгүй болсон малчдыг малжуулах ажлыг зохион байгуулах	Олон малтай нийт 12 өрх түрээсийн малчин авч ажиллуулж байна.	100,0
		3.4.Малгүй болсон иргэдэд зориулж сургалт явуулан үрээр хангах замаар хүнсний ногоо, тэжээлийн ургамал тариалж ургац хураах, хадлангийн салаа ажиллуулах, тэжээл үйлдвэрлэх, гэр тэжээл бэлтгэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, малчин өрх, баг, сум, аймаг бүр өвс, тэжээлийн нөөцтэй болох ажлыг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх	16 сумын малгүй болсон өрхийн 94 хүнийг мэргэжил олгох сургалтанд, 49 хүнийг ур чадварын сургалтанд хамруулж, 20 сумын 176 хүнийг нийтийг хамарсан ажилд ажиллууллаа.	100,0
		3.5. Мал ногоолуулах, оторлон таргалуулах, өвөлжүүлэх, хаваржуулах ажлыг багийн иргэдийн Нийтийн хурлаар хэлэлцүүлж, өвлийн бэлтгэлийг эртнээс хангах талаар малчин өрх бүртэй гэрээ байгуулж, хэвшүүлэн гэрээний дагуу талууд хариуцлага хүлээдэг тогтолцоог бий болгох	Өвлийн бэлтгэл хангах төлөвлөгөөг батлан ажилласнаар малчин өрхийн 96,7 хувь, багийн 96 хувь нь бэлтгэлээ хангасан байна. Өвлийн бэлтгэл хангах асуудлыг хөдөөний 86 багт хэлэлцэн ажилласнаар дээрхи үр дүн гарсан байна.	100,0

		4. “Мал аж ахуйн салбарт 2009-2010 оны өвөл, хаврын улиралд тохиолдсон зудын хохирлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг холбогдох Сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, төлөвлөгөөний биелэлтийг гаргаж хагас жил тутам Засгийн газарт танилцуулж байхыг Монгол улсын Шадар Сайд, Улсын Онцгой комиссын дарга М.Энхболд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайд Т.Бадамжунай нарт тус тус даалгасугай.	“Мал аж ахуйн салбарт 2009-2010 оны өвөл, хаврын улиралд тохиолдсон зудын хохирлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө”-г 24 суманд хүргүүлж, явцыг шалган хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар сумдад албан даалгавар хүргүүлж, хяналт тавин ажиллаж байна.	100,0
27	Малын гоц халдварт өвчин гарсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2010.06.23 дугаар 157	3.Шүлхий өвчний халдвар тархах эрсдэл өндөр байгааг харгалзан хорио цээр тогтоосон нутгаас малын шилжилт хөдөлгөөн хийх, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхгүй байх, баяр наадам болон олон нийтийг хамарсан үйл ажиллагааг хязгаарлах, Баян-Өлгий, Ховд, Увс, Хөвсгөл, Говь-Алтай, Завхан, Баянхонгор аймгуудад зүүн аймгуудаас мал сүргийг шилжүүлэхийг нэг жилийн хугацаагаар зогсоож, халдварын голомт илрээгүй Дорнод аймгийн сумдаас зөвхөн үйлдвэрийн аргаар боловсруулсан мах, анхан шатны боловсруулалт, халдваргүйтгэл хийсэн мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг төвлөрсөн хэрэгцээ, зах зээлд нийлүүлж байх арга хэмжээ авахыг ХХААХҮСайд Т.Бадамжунай, хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын дарга Я.Содбаатар, холбогдох аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	Шүлхий өвчин гарсан нутгаас мал амьтны шилжилт хөдөлгөөн хийгдээгүй, МАА-н бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлээгүй бөгөөд уг өвчнөөр өвчилсөн мал байхгүй болно.	100,0
28	Мал аж ахуйн салбарын 2010-2011 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай 2010.07.07 дугаар 166	2.Сүүлийн өдрүүдэд агаарын температур өссөнтэй холбогдуулан харс, агаар хэт халж, тариа бэлчээр гандах төлөвтэй байгааг харгалзан цаг агаарт зориудаар нөлөөлж, хур тунадас оруулах ажлын цар хүрээг нэмэгдүүлэх, малыг зуны оторт гарган таргалуулах, шаардлагатай газарт гангийн зэрэглэл тогтоох зэрэг арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг ХХААХҮСайд Т.Бадамжунай, БОАЖСайд Л.Гансүх, аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг 12 удаа зохион явуулсан нь үр дүнтэй арга хэмжээ боллоо.	100,0
		3.Мал сүргээ өөрийн нутаг, орон нутгийн отрын бэлчээрт болон гэрээ байгуулж, бусад аймаг, сумдын нутагт отор, нүүдлээр өвөлжүүлэх хуваарь гарган энэ оны 9-10 сард багтаан отор нүүдлийг зохион байгуулахыг аймаг нийслэлийн Засаг дарга нарт, даалгасугай.	Аймаг, сумдын оторчдын зөвлөгөөн зохион байгуулж, гадны 5 аймагт 72 өрхийн 69,1 мянган мал, хилийн зурваст 2 сумын 24,0 мянган мал, Отгонтэнгэрийн хамгаалалтын газарт 2 сумын 18,0 мянган мал, аймаг дундын отрын бүс нутагт 4 сумын 71,0 мянган мал отроор өвөлжиж байна.	100,0

		4,Дараах арга хэмжээг авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. А.ОХУ-аас тусламжаар өгсөн арвайгаар тэжээл үйлдвэрлэх болон хадлан, тэжээл бэлтгэх замаар энэ тогтоолын хавсралтаар баталсан өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх, байршуулах зохион байгуулалтын арга хэмжээ авах	Тусламжийн арвай болон орон нутгийн материал, түүхий эд, ашиглан малын тэжээл 145 тонныг үйлдвэрлэн аймгийн нөөцөд, мөн өвс 400 тн-ыг сумын нөөцөд , 1174 тонн өвс тэжээл бэлтгэн нөөцөлсөн байна.	90,0
		Б.Мал өвөлжилтийн бэлтгэл хангах чиглэлээр нутгийн захиргааны байгууллагын зүгээс зохион байгуулах үйл ажиллагаа болон малчид, мал бүхий иргэдийн хийх тодорхой ажлыг хамруулсан төлөвлөгөөг аймаг, нийслэл, сумд үүрэг бүрээр баталж, хэрэгжилтийг зохион байгуулан дүнг тухайн шатны ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж, мал өвөлжүүлэх, хаваржуулах төлөвлөгөөний хамт ХХААХҮЯаманд тайлагнах	Аймгийн 2010-2011 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангах төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг зохион байгуулж байна. Төлөвлөгөөнд заагдсан ажлуудыг шуурхай зохион байгуулах талаар сумдын удирдлагуудад 4 удаа зөвлөгөөн хийж, үүрэг өгөн явцыг шалгах ажлын хэсгийг 5 чиглэлд ажиллуулав. Малчин өрхийн 96 хувь нь бэлтгэлээ хангасан байна.	90,0
		В.Малын халдварт болон празиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга, угаалга, туулга зэрэг арга хэмжээг технологийн дагуу цаг хугацаанд нь хийлгэх болон өвөлжөө, хашаа, хорооны ариутгал, халваргүйтгэлийн ажлын явцад хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллах	Мал эмнэлгийн арга хэмжээнд давхардсанаар 4610,3 мянган мал хамруулж, 794,3 мянган м2 талбайд ариутгал, халваргүйтгэл хийгдлээ.	100,0
		Г.Хадлангийн болон тэжээл үйлдвэрлэх техникийн засвар үйлчилгээний ажлыг энэ оны 7 дугаар сарын 20-ны дотор дуусгаж, хадлангийн техникээр үйлчлэх ажлыг зохион байгуулж ажиллах	Газар тариалангийн үйлдвэрлэлд ажиллах трактор, комбайны дүүжин машины завсарыг холбогдох эздээр нь хийлгэсэн болно. Ургац хураалтыг дууссан. 616 тн үр тариа, 2584,5 тн ногоон тэжээл, 17,4 мянган тн хадлан бэлтгэлээ.	100,0
		Д. 2011 оны хаврын улиралд нийслэл, аймгийн төвийн хүн амын махны хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор мал бэлтгэж, махыг үйлдвэрийн аргаар боловсруулан нөөцлөх, дотоодын болон гадаадын зах зээлд нийлүүлэх арга хэмжээг холбогдох байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран зохион байгуулах	Аймгийн төвд мах боловсруулах, гурил үйлдвэрлэх үйл ажиллагааг эхлүүлж, мал нийлүүлэлт, аж ахуйн нэгж байгууллага, малчдын хооронд хийгдсэн гэрээгээр зохицуулагдаж байна.	50,0
		Е. Хээлтүүлэгч малын тооцоог гаргаж, дутагдалтай байгаа хээлтүүлэгчийг нөхөн тавиулах, худалдан борлуулах, малчид, иргэдийн захиалгын дагуу малын зохиомол хээлтүүлгийг зохион байгуулах	Хээлтүүлэгч малын тооцоог гарган шинээр хуц 1464, ухна 383-ыг сонгож тавьсан. Аймгийн төвд хээлтүүлэгч малын үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан. 20 суманд хуц 740, ухна 245-ыг хуваарилан олгож, үржилд үржилд ашиглуулахын зэрэгцээ Эрдэнэхайрхан суманд 200 эм хонинд зохиомол хээлтүүлэг хийсэн байна.	100,0
		Ж.Бэлчээр, хадлангийн талбай хаших, уст цэг гаргах, хадлан хадах, тэжээл бэлтгэх, түүхий эд боловсруулах, ахуйн үйлчилгээ үзүүлэх, малын удмын санг хамгаалах, малыг эрүүлжүүлэх зэрэг малчдад туслах чиглэлийн жижиг үйлчилгээг хөгжүүлэх ажлыг зохион байгуулах	“Дэлхийн зөн” хөдөө аж ахуй нэвтрүүлэх төв болон бусад байгууллагатай хамтран худгийн моторчны, мал эмчлэх, хээлтүүлэгч мал сонгон тавих, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх, сүү, цагаан идээ боловсруулах мэдлэг олгох сургалтанд 269 хүнийг оролцууллаа.	90,0

		3. Өвөлжилт хүндэрсэн нөхцөлд малчдад үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шаардагдах шатахуун болон шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх арга хэмжээ авах	Сумдын хөдөөгийн 88 багийн эмчийг тус бүр 100,0 мянган төгрөгний 20-30 нэр төрлийн эм бүхий эмийн сантай болгож, аймгийн Засаг даргын нөөц сангаас санхүүжүүллээ.	100,0
		И.Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг хангалтгүй зохион байгуулж байгаа сум, дүүргийн удирдлага, албан тушаалтантай хариуцлага тооцон ажиллах	Засгийн газрын 137, 166 дугаар тогтоол, түүнийг хэрэгжүүлэх талаар аймгаас 4 удаа өгсөн зөвлөмж, үүргийн хэрэгжилтийг аймгаас ажлын хэсэг гарган 24 суманд шалгаж, дутуу ажлыг гүйцээх хугацаатай үүргийг сумдын Засаг даргын Тамгын газарт өгч, биелэлтэнд хяналт тавин ажиллаж байна.	90,0
29	Улсын нөөцөд малын тэжээл бүрдүүлэх тухай 2010.09.01 дугаар 215	2.Тусламжийн буудайгаар үйлдвэрлэсэн тэжээлийг улсын нөөцийн салбар, цэгүүдэд байршуулах хэмжээ, тээвэрлэн хүргэх зардлыг хавсралт ёсоор баталсууй.	Улсын нөөцийн 5 цэгт 1700 тн хүчит тэжээл татагдсан байна.	100,0
30	Сумдад мал эмнэлэг, үржлийн нэгж байгуулах тухай 2010.09.01 дугаар 223	2.Сумын мал эмнэлэг, үржлийн нэгжийн үйл ажиллагаанд 2010 онд шаардагдах хөрөнгийг ХХААХҮ-ийн Сайдын багц дахь “Монгол мал” үндэсний хөтөлбөрийг 2010 онд хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэх арга хэмжээ авч, 2011 оноос эхлэн холбогдох зардлыг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж байхыг Сангийн Сайд С.Баярцогт, ХХААХҮСайд Т.Бадамжунай, аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	24 суманд шинээр байгуулагдсан Мал эмнэлэг, үржлийн тасагт 2010 оны хөрөнгийг өгч, 2011 оны зардлыг төсөвт тусгуулан ажиллаж байна.	100,0
		3.Сумын мал эмнэлэг, үржлийн нэгжийн хариуцах ажлын чиг үүргийг ХХААХҮЯамтай зөвшилцөн баталж мөрдүүлэхийг аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	Сумдын мал эмнэлэг, үржлийн нэгжийн мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарийг сумдад хүргүүлсэн.	100,0
		4.Сумын мал эмнэлэг, үржлийн нэгжийн ажилтныг давтан сургах, мэргэшүүлэх тусгай хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхийг БСШУСайд Ё.Отгонбаяр, ХХААХҮСайд Т.Бадамжунай, аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	24 сумдын мал эмнэлэг, үржлийн тасгийн мэргэжилтнүүдийг тусгай төлөвлөгөөний дагуу ХААИС-ийн 21 хоногийн сургалтанд хамрууллаа.	100,0
31	2009-2010 оны өвөл, хавар тохиолдсон зудын улмаас амьжиргааны эх үүсвэрээ алдсан зарим малчин өрхийг малжуулах түр журам батлах тухай 2010.07.20 дугаар 197	1. “2009-2010 оны өвөл, хавар тохиолдсон зудын улмаас амьжиргааны эх үүсвэрээ алдсан зарим малчин өрхийг малжуулах түр журам”ыг хавсралт ёсоор баталсууй.	“2009-2010 оны өвөл, хавар тохиолдсон зудын улмаас амьжиргааны эх үүсвэрээ алдсан зарим малчин өрхийг малжуулах түр журам”ын дагуу 24 сумын 394 өрхийг малжууллаа.	100,0
		2.Энэ тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, дүнг оны эцэст танилцуулахыг ХХААХҮСайд Т.Бадамжунай, аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Энэхүү журмын дагуу малжуулсан хүмүүсийн тайланг ХХААХҮЯ-нд хүргүүлсэн.	100,0

32	“Монгол мал” үндэсний хөтөлбөрийн эхний үе шатанд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах тухай 2010.09.01 дугаар 222	1.”Монгол мал” үндэсний хөтөлбөрийн эхний үе шатанд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.	.”Монгол мал” үндэсний хөтөлбөрийн эхний үе шатанд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг орон нутагт хэрэгжүүлэх асуудлыг түүвэрлэн авч, биелэлтийг хангуулах талаар сумдын Засаг дарга нарт зөвлөгөө өглөө.	100,0
		2.”Монгол мал” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, гадаад орон, олон улсын байгууллагын зээл тусламжинд хамруулах замаар санхүүжүүлж ажиллахыг Сангийн Сайд С.Баярцогт, Гадаад харилцааны Сайд Г.Занданшатар, ХХААХҮСайд Т.Бадамжунай, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	2011 оны төсөвт 230,0 сая төгрөг төлөвлөж, аймгийн ИТХ-ын хуралдаанд танилцууллаа.	90,0
		Байгаль орчин		
33	Журам батлах тухай 2007.10.03 дугаар 256	2.”Ган, цөлжилт, хуурайшилтын зэрэглэл тогтоох болон энэ үед мөрдөх усны нөөцийн менежментийн журам”-ын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймаг нийслэл сум дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Журмыг сумдад хувилан хүргүүлж, цөлжилтийн зэрэглэл тогтоох судалгааг сумдаас авч нэгтгэлээ.. Элсний нүүдэл, цөлжилттэй тэмцэх талаар төсөл бичиж гадаад дотоодын санхүүжүүлэгч байгууллагуудад хандаж, хөрөнгийн эх үүсвэр хайж байна. БНСУ-ын Хойт Чонг Чун мужийн газар тариалангийн компаний удирдлагууд, эрдэмтдийг урин ирүүлж, говийн бүсийн цөлжилтийг сааруулахад хамтран ажиллах боломжийг газар дээр нь судлуулж, 3 газар туршилтын тариалалт хийсэн нь үр дүнтэй боллоо. 2010 онд тариалалтыг нэмэгдүүлж 5 га талбайд тарьж ургуулж байна. Энэ төсөлд БНСУ-ын талаас 9.0 мянган ам долларын хөрөнгө оруулалт хийгдэхээр төлөвлөгдөж байгаа юм. Мөн 2009 онд аймгийн хэмжээнд 16.9 мянган мод, 2010 онд 49,0 мянган мод тарьсан.	90.0
34	Усны экологи, эдийн засгийн үнэлгээ батлах тухай 2008.02.06 дугаар 47	2.Усны нөөцийн хэмжээ, чанар, хэрэглээний ач холбогдол, учирсан хохиролыг үнэлэх, ус ашиглагч, түгээгч, хэрэглэгч, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг,хариуцлагыг тодорхойлоход усны экологи-эдийн засгийн үнэлгээг мөрдөж ажиллахыг ...аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Усны экологи эдийн засгийн үнэлгээг сумдад хүргүүлж, мөрдөж байна.	100.0
35	Түр журам батлах тухай 2008.02.27 дугаар 72	2.”Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж, туршилтын журмаар үе шаттайгаар зохион байгуулах арга хэмжээ авч ажиллахыг...аймаг сумдын дарга нарт үүрэг болгосугай.	Түр журмыг сумдад хувилан хүргүүлж, сурталчлах ажлыг зохион байгуулж байна. Одоогоор тус аймгийн нутагт хувиараа ашигт малтмал эрхэлж байгаа иргэд байхгүй байна.	100.0

36	Ой зохион байгуулалт хийх журам батлах тухай 2008.03.05 дугаар 85	2.Ой зохион байгуулалтыг мэргэжлийн байгууллагын хүчээр хийлгэж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улс, орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг...аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. /Ойн нөхөрлөл, ААН, байгууллагад ойг гэрээгээр эзэмшүүлж хамгаалуулах, ашиглуулах/	Ой зохион байгуулах журмыг сумдад хувилан хүргүүлж, сурталчлах ажлыг зохион байгуулж байна. Тус аймаг 2008 онд ой зохион байгуулалтыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, дүгнэлт гаргууллаа. Ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байна. Аймгийн хэмжээнд 2009 онд шинээр 11 нөхөрлөл байгуулагдаж, нийт 27 ойн нөхөрлөл ажиллаж байна.	100.0
37	Журам батлах тухай 2008.05.28 дугаар 190	2."Ургамалын хорио цээр тогтоосон үед баримтлах журам"-ын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыгбүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Журмыг бүх сумдад хувилан хүргүүлж, хэрэгжүүлэх талаар зөвлөмж өгч, мөрдөж ажиллаж байна.	100.0
38	"Ойн санг гэрээгээр эзэмшүүлэх журам" батлах тухай 2009.07.22 дугаар 227	2.Ойн сангийн тодорхой хэсгийг энэхүү журмын дагуу нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр эзэмшүүлэх замаар ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, зохистой ашиглах ажлын үр өгөөжийг дээшлүүлэх арга хэмжээ авахыг аймаг, сумдын засаг дарга нарт үүрэг болгосугай	Ойн санг гэрээгээр эзэмшүүлэх журмыг бүх сумдад хувилан хүргүүлж, сурталчлах ажлыг зохион байгуулж байна. 2009 онд 414 га-д ойжуулалтын, 30 га-д нөхөн сэргээх ажлыг хийж, ойн нөхөрлөлүүдэд ойн санг гэрээгээр эзэмшүүлж байна. 2010 онд 240 га-д ойжуулалт, 80 га-д байгалийн сэргэн ургалтанд туслах ажил хийж аймгийн комисст хүлээлгэн өглөө.	90.0
39	Ус ашигласны төлбөрийн хувь, хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2009.11.25 дугаар 351	1.Ус ашигласны төлбөрийн хувь, хэмжээг хавсралт ёсоор баталсугай. /Ашиг олох зориулалтаар ашигласан усны шоометр тутамд ...Завхан...Гадаргын ус 20 төг, Газрын доорхи ус 40 төг/	Энэ тогтоолыг бүх сум, холбогдох аж ахуйн нэгж, байгууллагуудад хувилан хүргүүлж ус ашигласны төлбөрийг энэ хэмжээгээр орон нутгийн төсөвт оруулж байна. 2010 оны 11 дүгээр сарын гүйцэтгэлээр Ус, рашаан ашигласны төлбөр 4159,3 мянган төгрөг төсөвт орж төлөвлөгөөний хэрэгжилт 110.6 хувьтай байна.	90.0

40	Журам батлах тухай 2010.03.10 дугаар 59	3."Ойд үзүүлэх хортой нөлөөллийг багасгасан, дэвшилтэд арга технологи нэвтрүүлсэн иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам"-ын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг...аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	"Ойд үзүүлэх хортой нөлөөллийг багасгасан, дэвшилтэд арга технологи нэвтрүүлсэн иргэн нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагыг урамшуулах журам"-ыг аймгийн хэмжээнд байгуулагдсан 27 нөхөрлөл, ойд цэвэрлэгээ хийх, ойжуулалт, ойг нөхөн сэргээх, мод үржүүлэх чиглэлээр эрх авсан мэргэжлийн байгууллагуудад хүргүүлэн ажиллаж байна. Ойд хортой нөлөөллийг багасгах зорилгоор ойн зохион байгуулалтын ажлыг 5 сумын 18 нөхөрлөлийн 39787 га талбайд мэргэжлийн байгууллага болох "Ойн такси" ХХК-аар гүйцэтгүүлж мэргэжлийн байгууллагаас гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.. Мөн ойн менежментийн төлөвлөгөөг 22 нөхөрлөлд хийж биелэлтэнд нь хяналт тавин ажиллаж байна. ГТХАН-ийн санхүүжилтээр Тосонцэнгэл, Их-Уул, Идэр сумын 9 нөхөрлөлийн ахлагч нарыг Сэлэнгэ аймгийн Мандал сумын 4 нөхөрлөлийн үйл ажиллагаатай танилцуулж туршлага судлуулсан. Ойд үзүүлэх хортой нөлөөллийг багасган, дэвшилтэд арга, технологи нэвтрүүлсэн ААНБайгууллагаар Ойн баялаг ХХК, Мөнхзандан ХХК-ныг шалгаруулж материалыг нь БОАЖЯаманд хүргүүлсэн.	70,0
41	Журам батлах тухай 2010.04.07 дугаар 85	1."Байгаль орчны мэдээллийн санг бүрдүүлэх, боловсруулах, түгээх, ашиглах, хадгалах, хамгаалах журам"-ыг 1 дүгээр, "байгаль орчны мэдээллийн сангийн эх мэдээний дэлгэрэнгүй жагсаалт"-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.	"Байгаль орчны мэдээллийн санг бүрдүүлэх, боловсруулах, түгээх, ашиглах, хадгалах, хамгаалах журам"-ыг сумдад хүргүүлэн хуучин мэдээллийн санг шинэ эх мэдээний жагсаалтын дагуу шинэчилж байна.	70,0
42	Цөлжилттэй тэмцэх хөтөлбөр батлах тухай 2010.04.14 дугаар 90	А.Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ болон тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсөвт тусган санхүүжүүлж хэрэгжүүлэх арга хэмжээ авсугай.	Цөлжилттэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. 2010 онд 18 инженерийн хийцтэй худгийг шинээр гарган,5 булгий эх ундаргыг сэргээж тохижуулан, 320 га-д ойг нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэж, 49199 ширхэг мод бут тарьж ургуулж байна. Бэлчээрийг талхлагдлаас сэргийлж бэлчээрийг өнжөөх, хашиж хамгаалах ажлыг хийж байна.	50,0
		Б.Хөтөлбөрийн зарим арга хэмжээг олон улсын байгууллагын зээл, тусламж, гадаад оронтой тогтоосон хоёр болон олон талт хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсугай.	Говийн сумдын элсний нүүлт, цөлжилтийг сааруулах төслийг бичиж гадаад дотоодын хандивлагч байгууллагад хандаж байна.	10,0

44	Талбайг нөөцөд авах тухай 2010.08.18 дугаар 205	1.Улсын төсвийн хөрөнгөөр геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн ажил хийж байгаа 1 дүгээр хавсралтад заасан талбайг нөөцөд авсугай.	Тус аймгийн Баянхайрхан, Баянтэс, Нөмрөг, Түдэвтэй, Тэлмэн, Отгон, сумдын Дүнгээн уул, Холбоо нуур, Бугатын нурууны солбицол бүхий талбайг нөөцөд авсан.	100,0
45	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын тухай 2010.07.14 дугаар 190	2.Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын хүрээнд ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс орон нутгийн төсөвт төлж байгаа татвар, төлбөр, хураамж, торгууль зэрэг орлого болон аймаг, нийслэл, сум дүүргийн ЗДТГ, төсөвт байгууллагад хандивлаж байгаа мөнгөн болон мөнгөн бус хөрөнгийн тайланг холбогдох маягтын дагуу жил бүр гаргаж, нийтэд мэдээлж, журмын дагуу тайлагнаж байхыг аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс орон нутгийн төсөвт төлж байгаа татвар, төлбөр, хураамж, торгууль зэрэг орлого болон орон нутагт хандивлаж байгаа мөнгөн болон мөнгөн бус хөрөнгийн тайланг авч нэгтгэн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2010 оны тайланг 2 дугаар сард Татварын ерөнхий газар болон Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай санаачлагыг хэрэгжүүлэх үүрэг бүхий үндэсний зөвлөлд хүргүүлсэн.	100,0
Үйлдвэрлэл, худалдаа, хүнсний хангамж				
46	Хүнсний аюулгүй байдлыг хангах, архидан согтуурахтай тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2008.01.04 дугаар 4	1.Хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор Хүнсний тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай зэрэг хууль тогтоомж болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм журмын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллахыг...аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Аймгийн нийтийн хоолны газрууд, согтууруулах ундаа болон хүнсний худалдаа эрхлэгчдэд мэргэжлийн байгууллагууд хамтран байнгын хяналт тавьж ажиллаж байна. Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дүгнэлтийг үндэслэн аймгийн Засаг даргын захирамжаар 49 цэг салбарын зөвшөөрлийг хүчингүй болголоо. Аймгийн хэмжээнд химийн бодисын тооллого явуулж, дүнг нэгтгэн холбогдох газруудад хүргүүлсэн.	90,0
		2.Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6.4-ийг хэрэгжүүлэх зорилгоор Үйлдвэр, худалдааны яамнаас баталсан согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тооны нормативийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Үйлдвэр, худалдааны сайдын тушаалаар баталсан согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тооны нормативийн хэрэгжилтийг хангах зорилгоор аймагт 2009 онд согтууруулах ундаа худалдаалдаг 145 дэлгүүр, согтууруулах ундаагаар үйлчилдэг 28 зоогийн газар, кафе, баарны үйл ажиллагаанд шалгалт хийж, зөрчил, дутагдалтай ажиллаж байгаа 49 цэг салбарын зөвшөөрлийг Мэргэжлийн хяналтын газрын дүгнэлтийн дагуу хүчингүй болголоо.	70,0

		3.Хүнсний аюулгүй байдлыг хангах, аюулгүй хүнс хэрэглэх, дадал, заншлыг хэвшүүлэх чиглэлээр иргэний нийгмийн байгууллага, үйлдвэрлэгчдийн холбоодын дэмжлэгийг авч, хамтран ажиллахыг... аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Хүнсний үйлдвэр эрхлэгчдэд “Хүнсний бүтээгдэхүүний технологийн заавар боловсруулах, бүтээгдэхүүний орц зохиох, гарцыг тооцих аргачлал” “Хүнсний аюулгүй байдал, сав баглаа боодол” “Бүтээгдэхүүний стандартчилал ба баталгаажуулалт” сэдэвт сургалтууд зохион байгуулж, тогооч нарын дунд ур чадварын уралдаан тогтмол явуулж байна. Талх нарийн боовны цехүүдэд шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авлаа. Аймгийн төвийн захаар худалдаалж буй мах сүү, цагаан идээнээс 7 хоног тутам дээш авч, ХХААЖДҮ-ийн газрын ариун цэврийн лабораторид шинжлүүлж, хүнсний аюулгүй байдал, стандартын шаардлагыг ханган ажиллаж байна.	90.0
47	Техникийн зохицуулалтын тухай 2008.04.30 дугаар 159	1.Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн техникийн зохицуулалтыг хавсралтын ёсоор баталж, 2008 оны10 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдсүгэй.	Аймагт согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхэлж буй үйлдвэрүүдэд тогтоолыг хувилж хүргүүлэн мөрдөж ажиллаж байна. Аймгийн архины 4 үйлдвэрийн технологичдыг Улаанбаатар хотод “Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн техникийн зохицуулалтыг хэрэгжүүлэх” сургалтад хамрууллаа.	100.0
48	Төлөвлөгөө батлах тухай 2008.06.25 дугаар 265	2.Энэхүү тогтоолоор баталсан төрийн байгууллагад чанарын удирдлагын тогтолцооны олон улсын ISO 9000 стандартыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг ...нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг...аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай 2.1.Төрийн байгууллагын удирдах ажилтнуудад зориулсан анхан шатны сургалт зохион байгуулж, гэрчилгээ олгох: в/ Аймгийн ЗДТГ-ын дарга нар /2008-2009 онд/ 2.3.Аймгийн чанарын менежерийн 3 өдрийн сургалт зохион байгуулах /2009 онд/	Стандартчилал, хэмжил зүйн төвөөс “Чанарын удирдлагын тогтолцооны олон улсын ISO 9000 стандартыг хэрэгжүүлэх сургалтыг аймагт зохион байгуулж, төрийн ба төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн удирдах ажилтнууд, үйлдвэрлэгчид, бизнес эрхлэгчдийн төлөөлөгчдийг хамруулж, 2008 онд 50 хүнд, 2009 онд 25 хүнд сертификат олголоо. Аймгийн чанарын менежерийн 3 өдрийн сургалтыг зохион байгууллаа.	90.0

49	Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл батлах тухай 2009.6.10 дугаар 178	4."Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл"-ийг хэрэгжүүлэх ажлыг тухайн нутаг дэвсгэртээ зохион байгуулж, хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд боломжтой бүхий л хэлбэрээр дэмжлэг үзүүлж ажиллахыг аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. /Завханд: Шилмэл сүргийн аж ахуй, сүү боловсруулах цех, жимс, жимсгэнэ боловсруулан савлах цех, загас үржүүлгийн аж ахуй, модон эдлэлийн үйлдвэр байгуулах/	Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлийн хүрээнд тус аймагт тэргүүлэх ач холбогдол бүхий үйлдвэрлэлийн 8 салбарыг тэргүүн ээлжинд хөгжүүлэхээр баталсан. Үүнд: Мах, ноос боловсруулах, сүү, сүүн бүтээгдэхүүний, жимс жимсгэний, мод модон эдлэлийн, барилгын материалын, рашаан савлах, улаан хальст сармиссыг эмийн ургамалын чиглэлээр үйлдвэрлэх . 2009 онд Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлттэй зээлд фермерийн аж ахуй 11, сүү цагаан идээний 4, жимс жимсгэний 2, ноосны чиглэлийн 6, мод модон эдлэлийн 7, барилгын материалын 6 үйлдвэрийг тус тус хамрууллаа.	90.0
----	---	--	---	------

50	2010 оныг “Бизнесийн орчны шинэтгэлийн жил болгох тухай” 2009.12.30 дугаар 377	4.”Бизнесийн орчны шинэтгэлийн жил”-ийн хүрээнд эрхэлсэн салбар, харъяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллаж, төрийн байгууллагуудаас хувийн хэвшил, иргэдэд үзүүлэх үйлчилгээг “нэг цонх” “нэг цэг”-ийн зарчимд шилжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	”Бизнесийн орчны шинэтгэлийн жил”-ийн хүрээнд аймагт хэрэгжүүлэх 3 бүлэг, 25 заалт бүхий төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, сумдаас үйлдвэрлэл эрхлэгчдийн болон бизнес эрхлэгчдийн судалгааг авч нэгтгэн хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбараар төрөлжүүлэн гаргаж, аймаг, орон нутгийн бизнесийн орчинд шинжилгээ хийж байна. Аймгийн аж үйлдвэрийн тэргүүлэх салбарыг хөгжүүлэх талаар 03 дугаар сард дулаан үйлдвэрлэгчид, газар тариалан эрхлэгчид болон сүү, ноос боловсруулах чиглэлийн жижиг үйлдвэрлэгчидтэй уулзалт ярилцлага зохион байгуулж, уурын зуухны үнсийг барилгын материалд ашиглах байдлаар хог хаягдлыг дахин боловсруулах, сармисны тариалалтыг хэрхэн нэмэгдүүлэх, өрхийн үйлдвэрлэлийг дэмжих талаар оновчтой саналуудыг дэвшүүлсэн. Мөн Бүс нутгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөр төслийн байгууллагатай хамтран 2010 оны 09 дүгээр сард бизнесийн хөгжлийг дэмжигч төрийн бус байгууллагуудтай хамтран уулзалт ярилцлага зохион байгуулж, аймаг орон нутагт жижиг дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийг хэрхэн дэмжих, хамтран ажиллах талаар харилцан санал солилцлоо. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих санд 2010 онд 650,0 сая төгрөгийн хөрөнгө төвлөрч, нийт 196 бизнес эрхлэгч 3,6 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл хүссэн төсөл ирүүлснийг аймгийн дэд комисс сонгон шалгаруулалт хийж 808,1 сая төгрөгийн 86 төслийг хадгаламж банкинд хүргүүлж, 70 иргэн, аж ахуйн нэгжид зээл олгосон. 01 дүгээр сарын 29-31-ний өдрүүдэд цагаан сарын баярыг угтсан “Эх орны шим-2010” үзэсгэлэн яармагийг зохион байгуулж, тус үзэсгэлэнд 5 сумын 35 үйлдвэр, аж ахуйн нэгж, 63 иргэд нийт 90 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 29,9 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Мөн 2010 оны 06 дугаар сард ОХУ-ын БНТыва болон Завхан аймгийн ЗДТГ-ын гэрээ хэлэлцээрийн дагуу “Сайн хөршийн түншлэл” хаврын үзэсгэлэн яармагийг, 08 дугаар сард “Арцсуурь школа-2010” үзэсгэлэн яармагийг тус тус Арцсуурь боомтод зохион байгуулсан. Аймагт “Нэг цонхны үйлчилгээний төв”-ийг байгуулж, иргэдэд 9 чиглэлийн 58 төрлийн үйлчилгээг нэг дороос үзүүлж байна.	100,0
----	--	---	---	-------

51	Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний талаар авах зарим арга хэмжээний тухай 2010,06,02 дугаар 138	4. 2011 оноос эхлэн Улаанбаатар хотод 12,0 мянган тонн, Дархан, Эрдэнэт хотод тус бүр 1,0 мянган тонн, бусад аймгийн төвүүдэд 100 тонноос доошгүй хэмжээний мах нөөцлөн, жил бүрийн хөврын улиралд борлуулах ажлыг зохион байгуулж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Аймаг, орон нутгийн хэрэглэгчдийг үйлдвэрийн аргаар боловсруулсан махаар хангах, махны экспортыг нэмэгдүүлэх зорилгоор Улиастай сумын Мах боловсруулах үйлдвэрийг 2010 онд ашиглалтанд оруулан, тус үйлдвэрийн аймгийн Засаг даргатай хамтран ажиллах Санамж бичигт аймгийн нөөцөд жил бүр 50-100,0 тн мах бэлтгэн нөөцөлж байхаар тусган хэрэгжүүлж эхлээд байна.	90,0
		5. Хаврын улиралд борлуулах нөөц махны урамшуулалд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусгаж байхыг Сангийн Сайд С.Баярцогт, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Мах хадгалж нөөцлөн хаврын улиралд борлуулах урамшуулалд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн тооцоо судалгааг жил бүр гаргаж байна. Аймагт мах боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг дэмжих, хаврын улиралд борлуулах махны нөөцийг хадгалахад тус үйлдвэрийн гэрэл цахилгааныг 24 цагаар тогтмол өгөх, дулаан болон инженерийн шугам сүлжээг найдвартай хэвийн ажиллуулах тал дээр хяналт тавин ажиллаж байна.	70,0
52	Монгол улсад Хүнсний аж үйлдвэр үүсч байгуулагдсаны 80 жилийн ой тэмдэглэх тухай 2010,06,09 дугаар 150	Монгол улсад хүнсний аж үйлдвэр үүсч байгуулагдсаны 80 жилийн ойг Засгийн газрын 1998 оны 234 дүгээр тогтоолоор баталсан “Түүхэн үйл явдлыг тэмдэглэх, төр, нийгмийн зүтгэлтэн, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь хүндэтгэх ажлыг зохион байгуулах журам”-ын 10-т заасны дагуу 2010 оны 12 сарын 2 дахь ням гаригт тэмдэглэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайд Т.Бадамжунай, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт зөвшөөрсүгэй.	Монгол улсад хүнсний аж үйлдвэр үүсч хөгжсөний 80 жилийн ойн арга хэмжээг угтаж аймгийн хүнс үйлдвэрлэгчдийн анхдугаар зөвлөгөөнийг 05 дугаар сарын 26-нд зохион байгуулж, уриалга зөвлөмж гарган хэрэгжүүлж, 12 дугаар сарын 17 – нд хүнсний аж үйлдвэр үүсч хөгжсөний 80 жилийн ойн арга хэмжээг аймаг орон нутагтаа тэмдэглэж, аймгийн хүнс үйлдвэрлэгч 300 гаруй иргэн, аж ахуйн нэгж оролцлоо.	100,0
53	Монгол улсын Ерөнхий Сайд Архангай, Хөвсгөл, Увс, Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Завхан, Баянхонгор, Өвөрхангай аймагт ажилласан мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай 2010.08.18 дугаар 202	Монгол улсын Ерөнхий Сайд Архангай, Хөвсгөл, Увс, Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Завхан, Баянхонгор, Өвөрхангай аймагт ажилласан мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай. /Ерөнхий Сайдын орон нутагт ажилласан мөрөөр арга хэмжээ авч хэрэгжүүлж ажиллахыг холбогдох Сайд нарт даалгасан байна./	Монгол улсын Ерөнхий Сайд Завхан аймагт ажилласан мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн удирдлагууд болон холбогдох хэлтэс, агентлагийн дарга нарт танилцууллаа.	100,0
		Дэд бүтэц, барилга, хот байгуулалт, газрын харилцаа		
54	Барилга, дэд бүтцийн салбарт авах зарим арга хэмжээний тухай 2007.10.31 дугаар 282	5а.Нийслэл болон аймаг, бүсийн тулгуур төв хот, сум суурин газрын нутаг дэвсгэрийн газар хөдлөлтийн бичил мужлалын зураг төслийг дэс дараатай боловсруулах	Баруун бүсийн тулгуур төв Улиастай хот болон 23 сумын газар хөдлөлтийн баллыг тогтоон мөрдөж байгаа бөгөөд шинээр баригдах барилга байгууламжид газар хөдлөлтийн баллыг тогтоон зураг төсөв хийлгэж байна.	90,0

		5б.Аймаг нийслэлд ажиллаж байгаа барилга хот байгуулалтын албадын үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд баталгаажуулан жигдрүүлж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтанд оруулсан барилга байгууламжийн иж бүрэн зураг төсөл, инженер геологийн дүгнэлт, дэвсгэр зураг, техникийн баримт бичгийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр бүх аж ахуйн нэгжийн мэдлээс авч, тус албанд шилжүүлж архивлах	Аймгийн барилга хот байгуулалтын алба 2007,01,01-нд байгуулагдан аж ахуйн тооцоон дээр ажиллаж байгаад 2008 оны Засгийн газрын 67 дугаар тогтоолын дагуу 2009 онд Газрын албатай нэгдэж, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар болон үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна. Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа, байгуулж, барилгын байгууллагуудыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр ханган ажиллуулж байна. Бүх барилга байгууламжтай холбоотой мэдээллийг төвлөрүүлж, шинээр ашиглалтад орсон барилга байгууламжийн зураг төсөв болон холбогдох техникийн бичиг баримтуудыг бүрдүүлж архивлаж, Төрийн Архивт тухай бүр нь шилжүүлж байна.	100.0
		5в.Барилга, авто зам, эрчим хүчний байгууламжийг бүртгэж, паспортжуулах журмыг 2008 онд багтаан шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх	Барилга байгууламжийн ашиглалт, өргөтгөл, шинэчлэл, их засварын хувийн хэрэг хөтлөх заавар, журам, ЗТБХБСайдын 2009 оны 71 дүгээр тогтоолын 2-р хавсралтаар батлагдаж, хувийн хэрэг ГХБХБГазарт хэвлэгдсэн. Барилга байгууламжийн судалгааг үндэслэн хувийн хэрэг хөтлөх ажлыг зохион байгуулж, Тэс, Баянтэс, Баянхайрхан, Асгат, Нөмрөг, Түдэвтэй, Сантмаргаз Улиастай сумдад тараан бичилт, бүртгэлийн ажил хийгдсэн. Аймгийн хэмжээнд барилгыг паспортжуулах ажил 60 хувьтай байна. Бусад байгууламжуудыг паспортжуулах бүртгэлийн ажил хийгдэж байна.	70.0
55	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2009.04.01 дугаар 93	1.Тендерийн урилга, үр дүнг Засгийн газрын Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим сүлжээнд /www.e-procurement.mn/ цаг хугацаанд нь бүрэн тавьж , гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэлийг нээлттэй, ил тод мэдээлж байсугай.	Аймгийн хэмжээний худалдан авах ажиллагааны тендерийн ажлыг хуулийн дагуу ВЭБ сайт болон өдөр тутмын сонинд зарлаж Боловсролын сайдын багцаас эрх шилжин ирсэн ажлуудаас хугацаа хоцорч ирсэн боловч Худалдан авах ажиллагааны бүх ажлууд хийгдэж дууссан.	100,0
		2.Захиалагч бүр жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдан авах ажиллагаанд хийсэн аливаа хяналт, аудитын тайлан, дүгнэлт, иргэд болон байгууллагаас гаргасан гомдлын тоо, агуулга, шийдвэрлэсэн байдлын талаар байгууллагын самбарт нийтэлж, нийтэд ил тод хүргэж байсугай.	Худалдан авах ажиллагааны төлөвлөөг тогтоосон хугацаанд гаргаж, Сангийн яаманд хүргүүлж, ВЭБ сайтад тавьсан. 2008, 2009 оны худалдан авах ажиллагаанд аудитын дүгнэлт хийлгэж, Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн. Худалдан авах ажиллагааны талаар гомдол гаргасан тохиолдол байхгүй байна.	100,0

		3.Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, ажилтнуудын мэдлэгийн түвшинг дээшлүүлэх болон худалдан авах ажиллагааны чиглэлээрх сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж байсугай	2009 оны худалдан авах ажиллагааг төлөвлөх, 2008 оны ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн талаар сумдын төрийн сангийн төлөөлөгчид, барилгын захиалагч, гүйцэтгэгчид, Нийгмийн даатгалын хэлтсийн ажилтнуудад 3 удаа сургалт явуулж, зөвлөмж гаргалаа. 2010 онд Сангийн яамнаас зохион байгуулсан 2 удаагийн сургалтанд худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэнг хамруулж мэргэжил дээшлүүлсэн.2010 онд Сангийн яамны мэргэжилтнүүдийн тусламжтайгаар худалдан авах ажиллагааг төлөвлөх сургалтыг орон нутагт зохион байгуулсан.	100,0
		4.Харьцуулалтын болон гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэхдээ хууль зөрчиж байгаа нийтлэг, дутагдлыг арилгаж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш өртөгтэй аливаа худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын журмын дагуу зохион байгуулж байсугай.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй ажлын тендерийг нээлттэй зарлаж, урилгыг ВЭБ сайт, Үнэн, Өдрийн сонинд ил тод нийтэлж, харьцуулалтын болон гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэхдээ хуулийн зөрчил гаргаагүй.	100,0
		5.Захиалагч бүр төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлд заасан захиалагчийн эрх, үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллан, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай бүрт мөн хуулийн 49.2-т заасан баримт бичиг, материалыг бүрдүүлж, архивын нэгж болгон хадгалж байсугай.	Хуулийн дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан. Хуулийн 49.2-т заасан бичиг баримтын бүрдүүлэлт 90.0 хувь байна. Барилга ашиглалтад оруулсны дараа Улсын комиссын акт, бусад бичиг баримтыг бүрдүүлж, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын архивт хадгалж байна. Бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаатай холбоотой бичиг баримтыг архивын нэгж болгон аймгийн архивт шилжүүлж, 2009, 2010 онуудын баримтыг архивын нэгж болгон архивлаж байна.	90,0

56	Өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай 2009.05.14 дугаар 142	1.Аймаг нийслэлийн ИТХ-ын саналыг үндэслэн 2009 онд улсын хэмжээнд иргэдэд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг хавсралт ёсоор баталсугай. Завхан аймаг: Өмчлүүлэх газрын нийт хэмжээ 147.88 га, иргэдэд үнэгүй өмчлүүлэх газрын нийт хэмжээ 143.28 /үүнээс одоо эзэмшиж байгаа 91.73, шинээр өмчлүүлэх 51..55/, аж ахуйн зориулалтаар 4.6 га /үүнээс төмс хүнсний ногооны 2.0 га, газар тариалангийнхаас бусад 2.6 га/	Иргэнд өмчлүүлэх газрын байршил, зориулалт, хэмжээг тогтоон аймгийн ИТХ-ын 2009 оны 09 тоот тогтоолоор батлуулан Газрын харилцаа, барилга геодези, зураг зүйн газарт хүргүүлэн 2010 онд аймгийн хэмжээнд нийт гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 315,37 га, аж ахуйн зориулалтаар 6,1 га газар өмчлүүлэхээр тусгаж, 461 иргэнд 32,27 га газрыг иргэдэд өмчлүүлж, төлөвлөгөө 11,0 хувийн биелэлттэй байна. Аж ахуйн болон газар тариалангийн зориулалтаар газар өмчлүүлэх ажлыг эрчимжүүлэх төлөвлөгөөнд тусган ард иргэдэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулсан боловч иргэдийн эдийн засгийн болон худалдан авах чадвартай холбоотойгоор энэ ажил хийгдэхгүй байна.	50,0
57	Барилга байгууламжийн зураг төсөл болвсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм батлах тухай 2009.07.08 дугаар 204	2.Барилга байгууламжийн зураг төсөл болвсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыгаймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	2010 онд шинээр баригдах барилга байгууламжуудын техникийн нөхцлийг бүрдүүлж, зураг төсвийг хийлгэн Завханмандал сумын ЗДТГ-ын конторын барилга, Тэлмэн сумын Соёлын төвийн барилга, Сантмаргаз сумын цэцэрлэгийн барилгын зураг төслийг экспертиз хийлгэсэн бөгөөд аймагт засварлагдах эмнэлгийн 2, сумын ЗДТГ-ын 3, цэцэрлэгийн 4, соёлын төвийн 1, сургуулийн 2 барилгын ажлын тоо хэмжээг авч зураг төсвийг хийлгэн аймгийн Мэргэжлийн байцаагч нараар хянуулан баталгаажуулах ажлыг зохион байгууллаа. 2011 оны хөрөнгө оруулалтын барилга, байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв хийгдэж, төсөв батлагдсан.	100.0

58	Зам тээвэр, барилга нийтийн аж ахуйн салбарын 2010-2011 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай 2010.07.07 дугаар 184	2.Орон нутгийн тээврийн болон барилга, орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагын өвлийн бэлтгэлийг хангуулж, түлээ нүүрс нөөцлөх, түлш шатахуун, сэлбэг хэрэгсэл татан авах ажлыг зохион байгуулах, төв суурин газрын барилга байгууламж, орон сууцны цэвэр, бохир ус, дулааны шугам сүлжээний ээлжит засвар үйлчилгээ, угаалга, туршилт, авто замын засвар арчлалтыг төлөвлөсөн хугацаанд нь хийж дуусгах арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд “Санмин” ХХК Улиастай сумын Богдын гол багийн хоёр 60 айлын шугамын шинэчлэл, мөн гадна 250 м шугамын шинэчлэл, нийтийн аж ахуйн цэвэр, бохир дулааны шугамын 158 ширхэг худаг угааж, станцуудын ус хүлээн авах камерын лагийг цэвэрлэж, засвар үйлчилгээг хийлгэн орон сууцны ойролцоох худгуудад 20 ширхэг цементэн таг шинээр хийж, цэвэрлэх байгууламжийн карт, шугам хоолойн хаалт, засвар үйлчилгээг бүрэн хийсэн. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангаж ажилласан болно. Мөн тусгай зөвшөөрөл бүхий 8 халаалтын зуух технологийн шинэлэлт хийснээр утааны хэмжээ багасаж, жилд зарцуулдаг нүүрсний хэмжээ 30 хүртэл хувиар буурсан. Одоогоор зуухнууд 1-6 сарын нөөцтэй байна. Загастай, Солонгот, Ганц, Согоотын даваануудад Завхан АЗЗА ХК-аас шуурхай групп гаран зам давааны цасыг арилган тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саадгүй явуулж байна.	100,0
59	Түлш, эрчим хүчний салбарын 2010-2011 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай 2010.07.07 дугаар 188	5.Аймгийн төв, сумдын эрчим хүчний үйлдвэрийн өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулж, нүүрс нөөцлөх, түлш, шатахуун татан авах ажлыг зохион байгуулан өөрийн нутаг дэвсгэр дээр байгаа цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, дулааны шугам, аваарийн болон сумдын дизель станцын засварыг графикт хугацаанд нь чанартай хийж дуусгахыг аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	Аймгийн хэмжээнд 0.4 кв-ын шугамын шинэчлэлт хийгдээгүй сумдын шугамыг шинэчлэх талаар саналаа Ерөнхийлөгчид болон ЭБЭХЯ-д удаа дараа хүргүүлсний дүнд 14 сумын шугам шинэчлэлийн хөрөнгө шийдэгдлээ.Сумдын эрчим хүчний хязгаарлалтыг багасгах үүднээс улсын төсвөөс 653.0 сая төгрөгийг шийдвэрлэн одоогоор 17 сумдыг улсын татаасаас 6-8 цаг эрчим хүчээр хангаж, зуны улиралд Богдын голын УЦС-аас Улиастай Алдархаан, Цагаанхайрхан, Идэрийн голын УЦС-аас Тосонцэнгэл, Завханмандалын Гацааны усан цахилгаан станцаас Эрдэнэхайрхан, Завханмандал, Цэцэн-уулын Боргионы УЦС-аас Сантмаргац, Цэцэн-Уул, Сонгино сумд, Ургамал, Дөрвөлжин сумд нарны цахилгааны эх үүсвэрээс 24 цагаар хангагдаж байна. Аймгийн төвийн эрчим хүчинд Улсын төвлөрсөн төсвөөс шинээр 2 дизель станц суурилагдаж байна.	100,0

60	Түлш, эрчим хүчний үйлдвэр, компанийн өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 2010,11,10 дугаар 291	2,1.Завхан аймгийн Эрчим хүчний үйлдвэрийн дизель станцын алдагдлын санхүүжилтэд олгохоор Монгол улсын 2010 оны төсөвт тусгагдсан хөрөнгөнөөс хэмнэгдсэн 250,0 сая төгрөгийг..... Эрдэс баялаг, эрчим хүчний Сайдын төсвийн багцад зохицуулалт хийж хэрэгжүүлэхийг ЭБЭХ-нй Сайд Д.Зоригт, ЗТБХБ-ын Сайд Х.Баттулга нарт даалгасугай.	Аймгийн Эрчим хүчний үйлдвэрийн дизель станцын алдагдлын алдагдлыг нөхөхөд зориулж төсвөөс санхүүжилт олгож байна.	100,0
61	Концесс олгох уралдаант шалгаруулалтын журам батлах тухай 2010.07.07 дугаар 177	1."Концесс олгох уралдаант шалгаруулалтын журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.	Журмыг хяналтанд авч, холбогдох хэлтэс, агентлагуудад хувилан хүргүүлж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.	100,0
		Эрүүл мэнд, спорт		
62	Нийтийн биеийн тамир спортын талаар авах зарим арга хэмжээний тухай 2009.01.07 дугаар 05	6.1.Иргэд биеийн тамир, спортоор хичээллэхэд зориулан гүйлт, алхалтын зам, дасгал, хөдөлгөөн, хийх, ногоон байгууламж бүхий ил талбай байгуулж, өвлийн улиралд байгалийн болон хиймэл мөс, цасан талбайг харьяа нутаг дэвсгэрийнхээ орон сууц, гэр хорооллын орчимд байгуулж, тогтмол ажиллуулах	Улиастай сумын 6 багт биеийн тамирын талбай байгуулж, өвлийн спортын бааз ажиллуулан уралдаан тэмцээн тогтмол зохион байгуулж, аймагт битнес клуб шинээр байгууллаа. Аймгийн хэмжээнд "Биеийн тамир-эрүүл мэнд" уриан дор зохион байгуулах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүллээ. Жил бүр уламжлал болгог зохион байгуулагдаг аймгийн Засаг даргын нэрэмжит спортын наадмыг үндэсний спортын 7 төрлөөр явуулж тэргүүнүүдийг шалгаруулав, Дэлхийн зөн олон улсын байгууллагын санхүүжилтээр Улиастай суманд Хүүхэд залуучуудын соёл амралтын хүрээлэн байгуулахаар Богдын гол багийн Чигэстэй голын дагуу 0.2 га газрыг хамгаалалтанд авч 22,5 ам \$ -ын хамгаалтын хайс хийн 1200 модыг тарьж, 55.000 ам \$-ын санхүүжилт ,18.5 ам \$- ын тоглоом бүхий хүүхэд залуучуудын соёл амралтын хүрээлэн байгуулан ашиглалтанд өгсөн.	100.0

		<p>6.2.Биеийн тамир спортын чигллээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын санаачлагыг бүх талаар дэмжиж ажиллах</p>	<p>Аймагт үндэсний бөхийн, сурын, теннисний, жу-до бөхийн, уулын аялал жуулчлалын холбоод ажиллаж, секц, дугуйлан хичээллүүлж байна. Эдгээр холбоод хамтарч, “Спортын холбоо” ТББ байгуулан төрийн байгууллагуудаас дэмжлэг үзүүлж байна. Их талын дуулиан ТТБ-тай хамтран “Дуулиан -2020” хөл бөмбөгийн тэмцээнийг 4 насны ангиллаар 2010 оны 3 дугаар сарын 28-30 ны өдрүүдэд Улиастай хотноо зохион байгуулж 300 гаруй баг тамирчид оролцсон Энэ төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд удирдлага , зохион байгуулалтын болон Засаг даргын Тамгын газраас 100,0 мянган төгрөгний дэмжлэг үзүүлсэн, Олон улсын Шри Чинмойн Марафоны багаас зохион байгуулсан даян дэлхийн эв найрамдлын гүйлт хэмээх бамбартай гүйлтийн 18 хүний бүрэлдэхүүнтэй багийг 2010 оны 6 дугаар сарын 2-3ны өдрүүдэд аймгийн Баянтэс, Тэс сумын нутаг дэвсгэрээр дайран өнгөрөх явцад угтан авч байр хоолоор ханган халуун усаар үйлчилж, тусгай хөтөлбөрийн дагуу хүндэтгэл үзүүлэн үйл ажиллагааг зохион байгуулсан.</p>	<p>100.0</p>
		<p>6.3.Аймгийн биеийн тамир, спортын байгууллагын үйл ажиллагааг идэвхижүүлж, чадавхийг нь дээшлүүлэх арга хэмжээ авах</p>	<p>Аймгийн Биеийн тамир, спортын хороог газар болгон өргөтгөж, мэргэжилтэн, дасгалжуулагчдыг сургалтанд хамруулж, мэргэжлийг дээшлүүлж, улсын болон бүсийн чанартай уралдаан тэмцээнд тамирчдыг оролцуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлж байна. Өсвөр үе залуучуудын 2009 онд улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилт гаргасан баг тамирчдад Засаг даргын нөөц сангаас 650,000 төгрөгний урамшуулал олгосон. Аймгийн Биеийн тамир спортын газрын даргыг Тайваны улсад зохион байгуулагдсан Монгол улсын биеийн тамир,спортын салбарын удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулсан.</p>	<p>100,0</p>

		6.4.Сумын соёл-спортын төв, аймгийн спортын ордонд иргэд биеийн тамир спортоор хичээллэх, уралдаан тэмцээн зохион байгуулах таатай орчин бүрдүүлэх арга хэмжээ авах	Аймгийн Биеийн тамир спортын газрын дэргэдэх бие бялдар чийрэгжүүлэлтийн танхимыг тохижуулж, шинээр баригдсан барилгын өргөтгөлийн хэсэгт амрах өрөө, халуун ус, шүршүүр, хувцас солих өрөө байгуулж, тамирчдад зориулсан хоолны газар нээлээ. Улиастай, Тосонцэнгэл, Ургамал, Завханмандал, Дөрвөлжин, Түдэвтэй, Их-уул, Сонгино, Цэцэн-уул, Нөмрөг Тэс сумдад явган аялалыг насны ангиллаар зохион явуулж, аялал хийх замдаа төрөл бүрийн спортын тэмцээнийг зохион байгуулах, байгалийн үзэсгэлэнт газар үзэх, малчдад туслах, Орчны бохирдолын хог цэвэрлэх зэрэг ажлыг хийж тэргүүлсэн баг тамирчдыг урамшуулсан. Сумын Засаг даргын Тамгын газар тус бүр таван зуун мянган /500.000/ төгрөгний дэмжлэг үзүүлсэн байна. Эрдэнэхайрхан, Сонгино сум, Улиастай сумын албан байгууллага 7 хоногийн Баасан гаригийг бүжгийн өдөр болгон бүжгийн хамтлаг хичээллэж байна. Улиастай, Цагаанхайрхан, Дөрвөлжин сумдад Биеийн тамирын гадаад талбайг байгуулж, тогтмол ажиллаж байна.	100.0
		6.5.Улсын хэмжээнд ашиглагдаж байгаа нийтийн биеийн тамир, спортын заал, танхим, гадна талбайн ашиглалтыг сайжруулах, цаашид зориулалтыг өөрчлөх, бусдад шилжүүлэх, худалдахыг хориглох чиглэлээр тодорхой арга хэмжээ авах	Аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган Биеийн тамир, спортын газрын ордонд өргөтгөл барьж, ашиглалтад орууллаа. Биеийн тамирын зориулалттай байгууламжийг хувьчлах, худалдах үйл ажиллагаа явагдаагүй.	100.0
		7.Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэхийг ...бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.	2009оны аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд “Эрүүл мэндийн төлөө хамтдаа” арга хэмжээнд 2.5 сая аймгийн Засаг даргын нэрэмжит “Хаврын хавар-2009” үндэсний спортын наадам зохион байгуулахад 3.0 төгрөгийг тусган арга хэмжээг хэрэгжүүлсэн, 2010 онд Үндэсний спортын IV наадам, Засаг даргын нэрэмжит “Хаврын баяр-2010” урлаг спортын наадмыг зохион байгуулахад аймгийн Засаг даргын нөөц сангаас 4 сая /4.000.000/ төгрөгний дэмжлэг үзүүлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд спортын 5 төрлөөр тэмцээн зохион байгуулахаар 500,0 мянган төгрөгийг тусган санхүүжүүлээд байна.	100.0

63	Үндэсний спортын IY их наадмыг 2010 онд зохион байгуулах тухай 2009.07.14 дугаар 211	1.Монголын үндэсний спортын IY их наадмыг 2010 онд орон даяар зохион байгуулахыг ...аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Их наадмыг зохион байгуулах аймгийн комиссын бүрэлдэхүүн, ажлын төлөвлөгөөг Засаг даргын 2010 оны захирамжаар томилон бэлтгэл ажлыг хангаж, I II шатны тэмцээнүүдийг орон нутагт ,спортын 7 төрлөөр зохион байгуулж, шалгарсан баг тамирчдыг Үндэсний спортын IV их наадмын III шатанд Үндэсний бөх, Сур харваа, Хасаа харваа төрлөөр улсын хэмжээнд зохион байгуулагдсан наадамд оролцууллаа.	100,0
		2.Их наадмыг орон нутагтаа зохион байгуулах, шигшээ наадамд оролцох баг, тамирчдын зардлыг төсвийн багцдаа тусгахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.	Үндэсний спортын IV наадмын I II шат, Засаг даргын нэрэмжит “Хаврын баяр-2010” урлаг спортын наадмыг аймгийн Засаг даргын нөөц сангаас 4 сая /4.000.000/ төгрөг, Шигшээ тэмцээнд оролцох баг тамирчдын зардал 1,0 сая төгрөгийг аймгийн эдийн засаг ,нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлсэн.	100.0
64	Үндэсний стратегийг сайшаах тухай 2009.07.29 дугаар 239	“Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих үндэсний стратеги”-ийн зорилт болон түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг өөрийн эрхлэх асуудлын хүрээ, харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хэрэгжүүлэхийг ...аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Ажлын байрны дасгал хөдөлгөөний сургалтыг аймагт 2 удаа зохион байгуулж, 60 гаруй хүн оролцлоо. Энэ чиглэлээр 13 сургагч багш бэлтгэгдэж, албан байгууллагуудын ажилтнуудад ажлын байрны дасгал хөдөлгөөн зааж, хийж хэвшлээ. “Хөдөлгөөн-Эрүүл мэнд” сарын аян зохион байгуулж, дүгнэсэн. Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран “Эх хүүхдийн хоол тэжээл” төслийг аймагт хэрэгжүүлж байна. Аймгийн эдийн засаг нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсаны дагуу “Эрүүл байхын төлөө хамтдаа” бүх нийтийг хамарсан зөв хооллолт-дасгал хөдөлгөөн арга хэмжээг зохион байгуулсан. Хүнсний баталгаат байдлын дэд хөтөлбөрийг боловсруулж аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар оруулж батлуулсан үйл ажиллагаа явагдаж байна.	100.0
65	Эрүүл мэндийн даатгалын 2010 оны шимтгэлийн хэмжээг тогтоох тухай 2009.12.30 дугаар 374	1.2010 онд аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны сар тутам төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг түүний хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 4 хувь байхаар тогтоосугай.	Бүх сум байгууллага, аж ахуйн нэгжид хувилан хүргүүлж мөрдөж ажиллаж байна	100,0

66	Үндэсний төлөвлөгөөний тухай 2010.02.17 дугаар 43 стратеги	3.ХДХВ/ДОХ, БЗДХ-аас сэргийлэх 2010-2015 оны Үндэсний стратеги төлөвлөгөөг... харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авахыг ...аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Аймгийн Засаг даргын захирамижаар ХДХВ/ДОХ,БЗДХ-ээс сэргийлэх үйл ажиллагааг зохицуулах салбар зөвлөл байгуулагдан үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажиллаж байна, 2010 оны 6 дугаар сард “ ХДХВ/ДОХ, БЗДХ-аас сэргийлэх үндэсний стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр үндэсний хорооны гишүүн байгууллага, орон нутгийн салбар зөвлөлийн чадавхийг бэхжүүлэх сургалт, семинарт салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга хамрагдсан. Үндэсний стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн салбар зөвлөлийн ажиллах дүрэм, журмыг баталж, сумдад салбар зөвлөл байгуулж ажлын чиг үүрэг, зөвлөмжийг хүргүүлсэн. Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сумдын хөдөөгийн 54 багт “ Төрийн цогц үйлчилгээг багт” уриан дор эмнэлгийн тусламж үйлчилгээ, сайн дурын зөвлөгөө шинжилгээний багийг ажилуулж, газар дээр нь ХДХВ/ДОХ,БЗДХ-аас сэргийлэх сурталчилгааг 1700 НҮ-н насны иргэдэд хийж, 10,000 орчим бэлгэвийг тараасан.БЗДХ өндөр байгаа Тосонцэнгэл, Их-уул, Шилүүстэй, Сантмаргац , Отгон сумдад БЗДХ-ын кабинетын эмч, бактериологи лаборант, сайн дурын зөвлөгөө шинжилгээний зөвлөгч бүхий багийг 10 хоног ажилууллаа.	90,0
67	Хүүхдийн спортын IV их наадам зохион байгуулах тухай 2010.08.18 дугаар 210	1.Монголын хүүхдийн спортын IV дүгээр их наадмыг 2010 оны 10 дугаар 1-нээс 2011 оны 08 дугаар сарын 20-ны хооронд орон даяар зохион байгуулахыг Эрүүл мэндийн Сайд С.Ламбаа, БСШУСайд Ё.Отгонбаяр, аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Монголын хүүхдийн спортын IV дүгээр их наадмыг зохион байгуулахаар аймгийн эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан.	50,0
		2.Их наадмын анхан шатны уралдаан, тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийг 2011 оны төсөвтөө тусган аймаг, орон нутгийн хэмжээнд зохих журмын дагуу зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, бүсийн болон шигшээ багуудын тэмцээн зохион байгуулахад шаардагдах хөрөнгийг Эрүүл мэндийн Сайдын 2011 оны төсвийн багцад тусган санхүүжүүлэхийг Сангийн Сайд С.Баярцогт, Эрүүл мэндийн Сайд С.Ламбаа нарт тус тус үүрэг болгосугай.	Их наадмын анхан шатны уралдаан, тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 4,0 сая төгрөгний хөрөнгийг 2011 оны төсөвт тусган, аймгийн Засаг даргын захирамжаар зохион байгуулах ажлын хэсэг томилогдон ажиллаж байна. Мөн Биеийн тамир спортын газрын дэргэд өсвөрийн шигшээ багийг 8 төрлөөр бэлтгэн хичээллүүлж байна.	50,0
		Боловсрол, соёл, шинжлэх ухаан		

68	Журам батлах тухай 2007.12.29 дугаар 359	1.Монгол Улсын шинжлэх ухаан технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох, тодотгол хийх журмыг хавсралтын ёсоор баталсугай. /2011-2015 онд тодорхойлох арга хэмжээг 2008 онд багтаан хэрэгжүүлэх, 4 жил тутам тодотгол хийх/	Тус аймаг дахь МУИС-ын Эдийн засгийн салбар сургуулийн дэргэд Эрдэм шинжилгээ судалгааны төв байгуулан ажиллуулж, Баруун аймгуудын Эдийн засгийн орчны, Завхан аймаг-жишиг аймаг эдийн засгийн орчны, Завхан аймгийн Боловсон хүчний нөөцийн судалгааг хийлгэж, орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийн бодлого тодорхойлох үйл явцад тусгаж байна. Цаашид баруун бүсийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах төв болгон өргөжүүлнэ. 2010 онд тус төв Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороотой хамтран аймгийн хөгжлийн Цогц бодлогыг боловсруулах үйл явцад идэвхитэй оролцлоо.	70,0
69	Нэрэмжит тэтгэлэгийн журам батлах тухай 2008.02.06 дугаар 46	1."Сурлага, спорт, урлагийн онцгой амжилт гаргасан суралцагчдад Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг олгох журам"-ыг баталж, нэрэмжит тэтгэлэгийг 2009.01.01-ний өдрөөс эхлэн олгосугай.	Журмыг аймагт үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн сургуулиудад хувилан хүргүүлж, хэрэгжүүлэх арга хэмжээг авч байна. Аймгаас нэрэмжит тэтгэлэгт хамрагдсан оюутан байхгүй байна.	70,0
70	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт батлах тухай 2008.05.14 дугаар 175	3.Улс аймаг нийслэлийн хамгаалалтанд байх түүх соёлын дурсгалын хадгалалт хамгаалалтад хяналт тавьж, ажиллахыгаймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. Завхан аймагт Улсын хамгаалалтанд байх 6 ширхэг, аймгийн хамгаалалтанд байх 5 ширхэг түүх соёлын дурсгал жагсаалтанд бүртгэгдсэн.	Аймгийн нутаг дэвсгэрт байгаа улсын хамгаалалтад байх 6 ширхэг, орон нутгийн хамгаалалтад байх 5 ширхэг түүх соёлын дурсгалт зүйлийг бүртгэн хамгаалалтад аваад байна Аймгийн Засаг даргын 2008 оны 136 дугаар захирамжаар Соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хамгаалах, сэргээн засварлах аймгийн дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна. Энэ ажлын хүрээнд аймгийн Музей мэргэжлийн байгууллагатай хамтран сумдын түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлүүдийг газар дээр нь үзэж бүртгэн, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх, орон нутагт хамгаалах талаар зөвлөгөө өгч, сумдын бүртгэл мэдээллийн санг аймгийн Музейд төвлөрүүлээ. Сумдад орон нутаг судлах танхим байгуулан үзмэртэй болгох ажлыг зохион байгуулж байна. Завхан нутгаас төрсөн алдартнуудын танхимыг өргөжүүлэхийн зэрэгцээ Улиастай хотод барьж байгуулсан хутагтуудын гүдэн цогцолбор, Дуун хөшөө, Монгол улсын баатар Б.Дорж, улсын хурц арслан М.Лхагвын хөшөө, Ш.Отгонбилэгийн нэрэмжит цэцэрлэгт хүрээлэн зэргийг орон нутгийн хамгаалалтанд аваад байна.	90,0

71	Ой тэмдэглэх тухай 2009.09.02 дугаар 269	2.Монголын үндэсний эрх чөлөөний төлөө тэмцэгч, Хотгойдын шадар ван Чингүнжавын мэндэлсний 300 жилийн ойг тэмдэглэх ажлыг зохион байгуулах хороог хавсралт ёсоор баталсугай. Дарга -Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяр Орлогч дарга-Хөвсгөл аймгийн Засаг дарга Л.Цэрэнжав Гишүүд: -...Завхан аймгийн Засаг дарга Я.Санжмятав	Аймгийн Засаг даргын захирамжаар Засаг даргын Тамгын газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. энэ ажлын хүрээнд Хөвсгөл аймгийн Мөрөн суманд зохион байгуулсан Хотгойд халх түмний дуу бүжгийн наадамд амжилттай оролцож, халх дууны төрлөөр 2 алтан медаль авлаа. Хотгойд түмэн сонины 1 дугаарыг эрхлэн гаргаж, Шадар ван Чингүнжавын амьдрал тэмцлийн түүхэн замнал, Монголын тусгаар тогтнолд оруулсан хувь нэмрийг сурталчлах олон хэлбэрийн арга хэмжээг зохион байгууллаа. 2010 оны 7 сарын 27-28-нд Хөвсгөл аймгийн Мөрөн суманд болсон ойн арга хэмжээнд аймаг, орон нутгийн төлөөлөгчид оролцсон.	100.0
72	Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2010.08.18 дугаар 212	4.Аймаг, нийслэлээс Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд суралцах ажилгүй иргэдийн квотыг тогтоон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлэхийг БСШУСайд Ё.Отгонбаярт, уг квотыг үндэслэн ажилгүй иргэдээ сургалтад хамруулах арга хэмжээг сайтар зохион байгуулах, энэхүү сургалтанд хамрагдах нь иргэдэд дэмжлэг, туслалцаа үзүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Тогтоолын хэрэгжүүлэх ажлын хүрээнд Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх ажлыг орон нутагт зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2010 оны 155 дугаар захирамжаар байгуулан Засгийн газраас баталсан квотын дагуу аймгийн МСҮТ, Тосонцэнгэл сумын салбарт бетонарматур, гагнуур, автозасвар, ойн нөхөн сэргээлтийн мэргэжлээр 80 хүнийг суралцуулахаар сонгон шалгаруулаад байна.	70,0
73	Их сургуулиудыг хотхоноор хөгжүүлэх чиглэл батлах тухай 2010.06.09 дугаар 149	3." Их сургуулиудыг хотхоноор хөгжүүлэх чиглэл"-ийг хэрэгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	МУИС-ийн Завхан сургууль, СУИС-ийн харьяа хөгжим бүжгийн коллежийг хотхоноор хөгжүүлэх талаар холбогдох судалгааг хийж байна.	30,0
Нийгэм хамгаалал				
74	Журам батлах тухай 2008.12.24 дугаар 72	3."Дайнд оролцсон ахмад дайчинд орон сууц эсхүл түүнтэй дүйцэхүйц хэмжээний мөнгөн тусламж олгох журам"-ын дагуу хүсэлт гаргасан ахмад дайчныг орон сууцаар хангах, мөнгөн тусламж олгох арга хэмжээ авахыг... аймаг нийслэлийн засаг дарга нарт үүрэг болгосугай.	Аймгийн хэмжээнд 1939 оны дайнд оролцсон 1, 1945 оны дайнд оролцсон 30 хүн, 1940-1948 оны баруун хилийн тулгаралтад оролцсон 14, бүгд 45 ахмад дайчны судалгааг гаргаж, холбогдох материалыг бүрдүүлэн БХЯ-ны Төрийн захиргаа удирдлагын газарт хүргүүлж, 21 ахмад дайчдад Улаанбаатар хотод орон сууц олгоод байна	90.0

75	Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2009.1.28 дугаар 26	2.Бүх шатны төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг тогтоосон хувь хэмжээгээр ажиллуулах, ажиллуулаагүй тохиолдолд зохих төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхий менежер нарт үүрэг болгосугай. /Аж ахуйн нэгж, байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй орон тоо тутамд сар бүр төлөх төлбөрийн хэмжээ аймагт хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 30 хувиар байна./	Аймгийн хэмжээнд 75 байгууллагад 129 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй байгууллагуудад аймгийн Засаг даргын албан бичиг хүргүүлж, хэрэгжүүлэх үүрэг өгч, 6 байгууллагад 2.3 сая төгрөгийн төлбөр тавьж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлээд байна. Сумдын Халамжийн асуудал эрхэлсэн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод энэ асуудлыг оруулж, үр дүнгийн гэрээнд тусгалаа.	90.0
76	Барилгын салбарт мэргэжилтэй ажилчин бэлтгэх зарим арга хэмжээний тухай 2009.01.28 дугаар 23	5."100 мянган орон сууц"-ны төслийн хүрээнд мэргэжилтэй ажилчин бэлтгэх төлөвлөгөөг жил бүр шинэчлэн баталж, шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсөв тусгай зориулалтын сан, зээл, тусламжийн эх үүсвэрээс бүрдүүлэх арга хэмжээ авч, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. /Төлөвлөгөөний 3 дахь заалт: Ажилгүй болон ажил идэвхитэй хайж байгаа иргэд, хугацаат цэргийн албан хаагчдыг барилгын салбарын мэргэжилтэй ажилчин бэлтгэх сургалтад хамруулах ажлыг зохион байгуулж ажиллах/	2009-2010 онуудад аймгийн хэмжээнд түр сургалтад өрөгч угсрагч 25, сантехникч 31 хүн, барилгын цахилгаанчин 30 хүн, засал чимэглэлийн мэргэжилтэн 70 хүнийг, аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг барилгын мэргэжлээр 175 хүүхдийг суралцуулж, тус тус төгсгөлөө. 2010 онд ХХҮХ-т мэргэжил олгох сургалтанд барилгын засал чимэглэл 50 хүн, цахилгаанчин 20 хүн, сан техникч 20 хүн, үйлдвэр дээрх сургалтанд 15 хүн тус тус хамруулан сургасан.Мөн оюу толгойн хөрөнгө оруулалтаар мэргэжилтэй ажилчин бэлтгэх сургалтанд бетон амрматурын ангид 20, гагнуурчин 20 хүнийг тус тус элсүүлээд байна.	100.0

77	Ажлын байрны аттестатчиллын дүнгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай 2009.04.22 дугаар 122	3.1.Аттестатчилалд амжилттай сайн дүн үзүүлсэн байгууллага, хамт олны туршлага, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн талаархи шинэ санаачлага, ажлын зөв эхлэлийг нийтийн хүртээл болгох	Ажлын байрны аттестатчилалд 433 аж ахуй нэгж байгууллага хамрагдсанаас 65 нь хангалтгүй, 58 нь сайн үнэлгээ авсанаас 40 байгууллагад батламж олгож, урамшуулсан. Эдгээр байгууллагын ажлын арга барил, орчныг сурталчилж, нийтийн хүртээл болгож байна. Аймагт Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороог ҮЭХолбоо, Ажил олгогч эздийн холбоо, Төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцуулан шинээр байгуулан ажлын төлөвлөгөөг боловсрууллаа. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай асуудлыг сумдын ЗДТГ-ын нийгмийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод оруулж, үр дүнгийн гэрээнд тусган ажиллаж байна. Аймгийн аж ахуйн нэгж байгууллагуудын үйлдвэрчний эвлэлийн хороонд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан Хөдөлмөрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч сонгон ажиллуулж эхэлсэн. Одоогоор нийт 25 байгууллагад ажиллаж байна. 2010 оны 04 дүгээр сард байгууллага, аж ахуйн нэгжүүдийн 250 ажилтанд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар болон хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар сургалт зохион байгуулж, орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчиллаа.	90.0
		3.2.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг нийгмийн түншлэлийн талууд, төрийн бус байгууллага, иргэдийн оролцоотойгоор зохион байгуулах	Улирлын чанартай ажилладаг уул уурхай, барилга, боловсруулах үйлдвэрлэл эрхэлдэг байгууллагуудад нөхөн аттестатчилал явуулж, хангалтгүй дүн үзүүлсэн байгууллагуудад дахин шалгалт хийхээр төлөвлөж, 5 барилгын компанид дахин аттестатчилал явуулаад байна.Аймгийн ЗДТГ, Мэргэжлийн хяналтын газар, Хүний эрхийн үндэсний хороо, аймгийн Үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтран Улиастай сумын 9 цэцэрлэг, мэргэжлийн 1 сургууль, Ерөнхий боловсролын 6 сургуульд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналт, шалгалт хийж, газар дээр нь зөрчлийг арилган, хуулийн хэрэгжилтийн талаар заавар, зөвлөгөө өгч ажиллаа.	90,0

		3.3.Аймгийн төрийн байгууллага, орон сууцны халаалтыг нэгдсэн системд шат дараатайгаар оруулах, нам даралтын зуухны тоог цөөрүүлэх, тэдгээрт ажиллагсдын хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах	Аймгийн төвд тусгай зөвшөөрөлтэй 13 халаалтын зуух болон 31 нам даралтын зуухнууд ажиллаж, албан байгууллага, айл өрхүүдийг халааж байна. Эдгээрийн тоог цөөрүүлэх, аймагт Дулааны үйлдвэр байгуулах талаар УИХ-ын гишүүд, Засгийн газар, холбогдох яамдад саналаа удаа дараа хүргүүлсээр байна. Аймгийн төвийн төвлөрсөн 8 уурын зууханд техникийн шинэчлэл хийлээ.	90,0
		3.4.Зураг төсөл нь хянагдаагүй, хориотой бүс, зөвшөөрөлгүй газарт барилга байгууламж шинээр барих явдлыг таслан зогсоох, нэг хүнд ноогдох ажлын байрны талбайн хэмжээ, барилга байгууламжийн чанар, стандартын хэрэгжилтэд орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагаас тавих хяналтыг сайжруулах	Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй объектуудад шалгалт хийхэд зураг төсөл нь хянагдаагүй болон зөвшөөрөлгүй газарт барилга байгууламж баригдсан зөрчил гараагүй байна. Хувийн хэвшлийн байгууллагуудын барьж буй барилгуудад хяналтын хэсэг томилон шалгалт хийлээ. Галын аюултай бүс, төв суурин газруудад баригдсан аймгийн төвийн бүх шатахуун түгээх станцуудад шалгалт хийж, улсын Мэргэжлийн хяналтын газраас зөрчил арилгуулах дүгнэлт гаргуулан Газрын тосны Хэрэг эрхлэх газарт хүргүүлээ.	70,0
80	Иргэн бүрт 1.5 сая төгрөг хүртээх талаар авах арга хэмжээний тухай 2010.04.02 дугаар 84	7.Иргэн бүрт 1.5 сая төгрөг хүртээх талаар Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа ажлыг ...холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Иргэнд хувь хишиг хүртээх ажлыг эрчимжүүлэх, олон нийтэд сурталчлах зорилгоор аймгийн радио, телевизээр 4 удаагийн нэвтрүүлэг бэлтгэн гаргаж, 4 дүгээр сард нээлттэй хаалганы өдрийг Улиастай суманд зохион байгуулсан. Холбогдох зөвлөмж, мэдээллийг 24 сум болон иргэд олон нийтэд байнга хүргэн ажиллаж байна. Мөн 11 суманд хөдөлмөрийн бирж зохион байгуулж, ард иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн мэдээ, мэдээлэл, зөвлөмжийг газар дээр нь хүргэж ажилласан. Иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгүүлж иргэний харъяалалын зөрчилгүй болсон 49011 иргэний нэрсийн жагсаалт ИБЕГ-аас ирсэн бөгөд энэ нь хүн амын 65 хувийг хамарч байгаа юм. Үүнээс 28010 иргэнд сар бүрийн 10000 төгрөгийг олгоод байна.	90,0
81	Иргэнд хишиг хувь хүртээхтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2010 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн 3 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай 2010.07.20 дугаар 193	"Иргэнд хишиг хувь хүртээхтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2010 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн 3 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийг дор дурьдсанаар өөрчлөн найруулсугай.	Хүний хөгжил сан"-гаас иргэн бүрт хишиг, хувь хүртээх ажлыг зохион байгуулах журмын дагуу бүртгэлийг явуулж, нийт хүн амын 95,6 хувь, буюу 71626 хүнд 70000 төгрөгийг, 28010 хүнд сар бүрийн 10000 төгрөгийг тус тус олгоод байна.	100,0

		Төрийн захиргааны удирдлага		
82	Журам батлах тухай 2006.07.05 дугаар 160	1.“Хууль тогтоомж ,Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүн биелэлтийг дүгнэх, мэдээлэх журам ”-ыг хавсралт ёсоор баталсугай.	Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг журмын дагуу зохион байгуулж, үр дүн биелэлтийг дүгнэн улирал тутам Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт мэдээлж байна. 2010 оны жилийн эцсийн байдлаар 141 шийдвэрийн 231 заалтыг хяналтад авч хэрэгжилт 96.42 хувьтай байна.	100.0
83	Журам батлах тухай 2010.01.13 дугаар 11	1.“Яам болон аймаг нийслэлийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай	Энэхүү журмын дагуу аймгийн Засаг даргын 2009 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, дүнг ЗГХЭГ-т албан бичгээр хүргүүлсэн. Мөн энэхүү журмаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөр, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламж, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, яамдын сайдтай байгуулсан гэрээний үүргийн биелэлт, эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ зэрэг бодлогын баримт бичгүүдийн биелэлтийг тооцож байна. Тогтоолыг хэлтэс, агентлаг, сумдад хувиран хүргүүлж, сурталчилж, хэрэгжүүлэх арга хэмжээ авч байна.	100.0
		2.Засгийн газрын агентлаг, сум дүүргийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журмыг баталж, мөрдүүлэхийг сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Аймгийн хэмжээнд сум, баг, хэлтэс, агентлагуудын ажлыг дүгнэх журам, дүрмийг аймгийн Засаг даргын захирамжаар шинэчлэн баталж, үйл ажиллагаандаа мөрдөж байна.	100,0

84	Сургалт семинарын зохион байгуулалтыг сайжруулах тухай 2008.11.12 дугаар 32	За.Сургалт, семинарын нэгдсэн хуваарийн биелэлтэд байнга хяналт тавьж, төлөвлөгдсөн арга хэмжээнд ажилтнуудаа оролцуулан, тэдгээрийн томилолтын тайлан, үр дүнг тогтмол дүгнэж байх	2010 онд төвийн болон орон нутгийн сургалтад төрийн албан хаагчдыг хамруулах төлөвлөгөө батлан хэрэгжүүлж, үр дүнг тооцон ажиллаж байна. Төрийн албан хаагчдыг сургалтад хамруулах, мэдлэг чадварыг нь дээшлүүлэх, дадлагажуулах зорилгоор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, нарийн бичгийн дарга, Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга, албан хаагчдад давхардсан тоогоор 9 удаа сургалт зохион байгууллаа. Аймгийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх агентлаг, төрийн байгууллагуудын албан хаагчид холбогдох салбарын хүрээний сургалт семинарт давхардсан тоогоор 358 албан хаагч, орон нутгийн сургалтад давхардсан тоогоор 2150 албан хаагч хамрагдаж, Санхүү Эдийн засгийн дээд сургуулийн магистрын сургалтанд 25 хүнийг, Удирдлагын академийн дипломын дараах улирлын ангид 7 хүнийг суралцуулж байна. Мөн бакалаврын шатны сургалтыг 2 хүн төгсөж одоо 4 хүн суралцаж байна. Шведийн SIPU интернэйшнэл төсөл, Төрийн албаны зөвлөлтэй хамтран төсвийн байгууллагын 40 Ерөнхий менежерд манлайллын сургалтыг тус тус зохион байгууллаа.	100.0
		Зв.Гадаад оронд зохион байгуулагдах сургалт, семинарт оролцохдоо ЗГХЭГ-аас зөвшөөрөл авч, томилолтоор ажилласан дүнгээ тайлагнаж, өөр аймаг, нийслэлд ажиллахдаа тухай бүр мэдэгдэж байх	Гадаад харилцаа хамтын ажиллагаатай Бүгд найрамдах Солонгос улсад Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга, Хууль зүйн хэлтсийн дарга, Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн болон сумдын Засаг дарга нар ажлын айлчлал хийж, Солонгос улс даяар өрнөөд байгаа “Шинэ тосгоны хөдөлгөөн”-ий үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлаад ирлээ. Мөн ОХУ-ын Бүгд Найрамдах Тува Улсын Засгийн газрын тэргүүний урилгаар манай аймгийн Засаг дарга холбогдох хүмүүсийн хамт 2010 оны 05 дугаар сарын 7-10-ны өдрүүдэд айлчлал хийлээ.	90.0
		Зв.Сумын Засаг дарга, ЗДТГ-ын болон төсвийн бусад байгууллагын ажилтнуудын дотоод, гадаад албан томилолтын жилийн хуваарийг батлан мөрдүүлж, зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд томилолт олгохгүй байх	Албан томилолтын зардлын хуваарийг сар, улирлаар төлөвлөн хуваарилж байна.	90.0

85	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай 2009.01.07 дугаар 01	2.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хугацаанд нь шуурхай хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллан хэрэгжилтийн явцад жил бүрийн 6, 12 дугаар сарын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Засгийн газрын үйл ажиллагааны 2008-2012 онд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тус аймагтай холбоотой 170 арга хэмжээ тусгагдсаныг хяналтад авч, салбар нэгжүүдэд хувиран хүргүүлж биелэлтийг тооцон Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлж байна. Мөн тус төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн болон эдийн засаг нийгмийг хөгжүүлэх жил жилийн үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.	90,0
86	Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай 2009.05.14 дугаар 143	2./Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт/ -ийг хангах арга хэмжээ авч ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай. Үүнд:1.Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал. 2.Хүний нөөцийн бодлогын ил тод байдал 3.Төсөв, санхүүгийн ил тод байдал 4.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал	Ил тод байдлын үнэлгээний тайланг шалгуур үзүүлэлт бүрээр дүгнэж ЗГХЭГ-т хүргүүлээ. 2009 оны байдлаар үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлын үнэлгээ 97,14 хувь, Хүний нөөцийн бодлогын ил тод байдлын үнэлгээ 96,6 хувь, Төсөв, санхүүгийн ил тод байдал 97,14 хувь,Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлын үнэлгээ 97 хувьтай дүгнэгдлээ.	90.0
87	Журам батлах тухай 2009.06.03 дугаар 164	1."Төрийн жинхэнэ албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ыг хавсралт ёсоор баталсугай	Журмыг бүх сумдын ЗДТГ болон төрийн захиргааны байгууллагуудад хувиран хүргүүлж, хэрэгжүүлэх арга хэмжээ авч байна.	100.0
		3.Санхүү, эдийн засгийн хүндрэлтэй холбогдуулан Төрийн албаны тухай хуулийн 24.1.1-д заасан насанд хүрсэн төрийн жинхэнэ албан хаагчийг өөрийнх нь саналыг харгалзан үргэлжлүүлэн ажиллуулах, төрийн албанаас чөлөөлөх дараалал тогтоох замаар төсөвт хэт ачаалал үүсгэхгүй байх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхий менежер нарт даалгасугай.	Өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрч эрх үүссэн 41 төрийн албан хаагч нэг удаагийн буцалтгүй тусламж авах саналаа ирүүлснээс дараалал тогтоож, эхний 13 хүнд олгохоор 2010 оны төсөвт суулгаж, материалыг Сангийн яаманд бүрдүүлэн хүргүүлж, тэтгэмжийг олгосон.	90.0
88	Болзол батлах тухай 2009.07.01 дугаар 193	1."Улсын тэргүүний /загвар/ сум шалгаруулах болзол"-ыг хавсралт ёсоор баталсугай. /2 жил тутамд шалгаруулна/	Болзлыг бүх сумдад хувиран хүргүүлж, сурталчилж байна. Сумдын ажил дүгнэх үзүүлэлтүүдийг аймгийн Засаг даргын 2009 оны 185 дугаар захирамжаар шинэчлэн баталж, болзолд заасан үзүүлэлтүүдийг журамд бүрэн оруулж, 2009 оны ажлыг дүгнэсэн. 2010 онд Тэргүүний /загвар/ сум шалгаруулах болзолд Улиастай сумын материалыг шалгаруулж баруун бүсийн зөвлөлд хүргүүлээ.	90.0

89	Журамд нэмэлт оруулах тухай 2009.09.16 дугаар 285	4.17.Төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллага нь Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоолоор баталсан үндэсний хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн удирдлага, зохицуулалт болон үр дүн, биелэлтэд нь хяналт тавьж, явц, дүнд хяналт шинжилгээ хийж, хэрэгжилтийн үр дүн, мэдээг энэхүү журмын 5, 6, 7 дугаар хавсралт ёсоор гарган, хагас жилийн дүнг 8 дугаар сарын 20-ны дотор, бүтэн жилийн дүнг дараа оны 4 дүгээр сарын 20-ны дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.	Журмыг холбогдох газруудад хувилан хүргүүлж, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж байна. Хөтөлбөрүүдийн биелэлтийн 2009, 2010 оны тайланг энэ журмын дагуу гаргаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Хөтөлбөрүүдийн биелэлт 2010 оны эхний хагас жилийн байдлаар 59,7 хувьтай, хөтөлбөр хэрэгжсэнээс хойшхи хугацааны гүйцэтгэлээр 67,0 хувьтай байна.	90.0
		4.20.Төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллага нь Үндэсний хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн байдал, үр дүн, явцын талаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэх, жилийн эцсийн дүнг дэлгэрэнгүй тайлантай хамт ирүүлнэ.	Хөтөлбөрүүдийн биелэлтийн 2009, 2010 оны дэлгэрэнгүй тайланг энэхүү журмын дагуу гаргаж, ЗГХЭГ-т хугацаанд нь хүргүүлсэн.	100.0
90	Журам батлах тухай 2009.12.11 дугаар 368	1.Төрийн албан хаагчдыг орон сууцны зээлд хамруулах журмыг хавсралт ёсоор баталсугай.	Төрийн албан хаагчидын орон сууцны зээлд хамруулах журмын дагуу зээлэнд хамрагдах хүсэлтэй төрийн албан хаагчдын материалыг бүрдүүлэн орон сууц санхүүжилтийн корпорацид хүргүүлж байна. Мөн орон нутагт “Улиастай 200” хөтөлбөрийн дагуу 30 айлын орон сууцыг 2009 онд, төрийн албан хаагчийн 20 айлын орон сууцыг 2010 онд ашиглалтанд тус тус оруулж, төрийн албан хаагчдыг зээлэнд хамруулах ажлыг зохион байгууллаа.	90,0
91	Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах тухай 2010.03.24 дугаар 69	2.Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хугацаанд нь хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан аймагтай холбоотой заалтуудыг хяналтанд авч, биелэлт, үр дүнг тооцон ажиллаж байна.	100,0
92	Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтэд эхний шатны үнэлгээ хийх төлөвлөгөө батлах тухай 2010.04.14 дугаар 95	2.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хүрээнд Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтэнд 2010.06.30-ны байдлаар эхний шатны үнэлгээ хийх бэлтгэлийг хангах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтэнд үнэлгээ хийх төлөвлөгөөний дагуу хяналт, шинжилгээ хийж, үнэлгээ өгөх ажлыг зохион байгуулж байна.	70,0

93	Гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдсэн зохицуулалтыг сайжруулах тухай 2010.06.30 дугаар 162	Засгийн газрын гишүүд, аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгах нь: 1.1.Үндэсний аюулгүй байдал, гадаад бодлоготой холбоотой, хөгжлийн томоохон асуудлаар яриа, хэлэлцээ хийхдээ гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын төлөөллийг оролцуулж байх	Тогтоолын дагуу холбогдох хүмүүст үүрэг, чиглэл өгч, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Үндэсний аюулгүй байдал, гадаад бодлоготой холбоотой, хөгжлийн томоохон асуудлаар яриа, хэлэлцээ хийх хүрээнд 2010 оны 05 сарын 8-10-ны өдрүүдэд ОХУ-ын БНТУ –д Тува улсын ЗГ-ын тэргүүн Кара-оол.Ш.В-ийн урилгаар албан ёсны айлчлал хийхдээ Монгол улсаас Кызыл хотод суугаа Ерөнхий консул Д.Базарсад, дэд консул Ганболд нарыг оролцуулав.Энэ үеэр хамтын ажиллагааны 7 зүйл, 21 заалт бүхий санамж бичигт гарын үсэг зурлаа.	50,0
		1.2.Монгол улс болон Засгийн газрыг төлөөлөн олон улсын хуралд оролцох төлөөлөгчдөд гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаар эрхийн үнэмлэхийг хугацаанд нь олгуулж байх	Монгол улс болон ЗГ-ыг төлөөлөн олон улсын хуралд оролцох төлөөлөгчдөд гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаар эрхийн үнэмлэхийг хугацаанд нь олгуулж байх тал дээр анхааран ажиллаж байна.	50,0
		1.4.Аймаг нийслэлийн Засаг даргын түвшинд хэрэгжүүлэх айлчлал, арга хэмжээний талаар Засгийн газрын хэрэг эрхлэх газар болон гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай урьдчилан зөвшилцөж, илтгэх хуудсыг тухай бүр ирүүлж байх	2010 оны 05 сарын 8-10-ны өдрүүдэд ОХУ-ын БНТУ –д Тува улсын ЗГ-ын тэргүүн Кара-оол.Ш.В-ийн урилгаар албан ёсны айлчлал хийсэн ба энэ тухай гадаад харилцааны тайлан мэдээнд тусган ГХЯ-нд хүргүүлэв. 2010 оны 11сарын 21-29 нд аймгийн Засаг даргын Финланд Улсад, яамд болон ЗГ-ын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд оролцон албан ёсны айлчлал хийсэн талаар ЗГХЭГ болон гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай урьдчилан зөвшилцөж, илтгэх хуудсыг хүргүүлсэн болно.	50,0
		1.5. Сум, дүүргийн Засаг даргын түвшинд хэрэгжих гадаад айлчлал, арга хэмжээний талаар аймаг, нийслэлийн Засаг дарга нарт удирдамж, чиглэл өгч байх	Тогтоолын дагуу холбогдох хүмүүст үүрэг, чиглэл өгч, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.	50,0
		1.6. Гадаадын ижил төрлийн байгууллагатай аливаа асуудлаар хамтын ажиллагааны баримт бичиг байгуулахдаа гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай урьдчилан зөвшилцөх	Тогтоолын дагуу холбогдох хүмүүст үүрэг, чиглэл өгч, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.	50,0
		1.7.Гадаад хамтын ажиллагааны тухай мэдээллийг хагас жил тутам, тайланг жилийн эцэст гаргаж, гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж байх	Аймгийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, Гадаад харилцааны Яаманд тогтмол хүргүүлж байна.	100,0

94	“Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам” батлах тухай 2010.07.07 дугаар 172	2. “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам”-ын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг БСШУСайд Ё.Отгонбаяр, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	“Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам”-ын холбогдох газруудад хувилан хүргүүлж мөрдүүлэн хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.	100,0
Хууль, хяналт				
95	Журам батлах тухай 2009.01.28 дугаар 28	2.Хэн болох нь тогтоогдоогүй, хариуцах эзэнгүй хүний цогцос оршуулах журмыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүр төсөвтөө тусган шийдвэрлэж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Аймагт Шүүхийн шинжилгээний алба байгуулагдаж, үйл ажиллагааны үүрэг чиглэлд нь энэ асуудлыг хамруулж байна. Аймагт хэн болох нь тогтоогдоогүй, хариуцах эзэнгүй цогцос гараагүй байна.	100,0
96	Стандарт мөрдүүлэх тухай 2010.2.24 дугаар 44	1.Компьютерын кирилл болон монгол үсгийн нэгдсэн кодын MNS-5552:2005 стандартыг төрийн байгууллагуудын албан хэрэгт мөрдүүлсүгэй.	Компьютерын кирилл болон монгол үсгийн нэгдсэн кодын MNS-5552:2005 стандарт болон стандартыг хэрэглэх тухай зөвлөмж боловсруулж 24 сум болон төрийн байгууллагуудад хүргүүлсэн. Дээрхи стандартын хэрэгжилтийн талаар аймгийн Засаг даргын Тамгын газраас хяналт тавин ажилласнаар хэрэглэж хэвшээд байна.	100,0
97	Төлөвлөгөө батлах тухай 2010.02.17 дугаар 40	2.Терроризмоос сэргийлэх арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хариуцсан...нутаг дэвсгэртээ зохион байгуулан хэрэгжүүлж ажиллахыг ...аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай	Аймгийн Засаг даргын 2010 оны “Дэмжлэг үзүүлэх тухай” 130 дугаар захирамжаар “Терроризмтэй тэмцэх ажиллагааг зохицуулах салбар зөвлөл”-д таван зуун мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Тус зөвлөл нь Ховд аймагт Монгол Улсын ТТАЗЗ-өөс зохион явуулсан “Сөрөг тусгай ажиллагааны шуурхай штабыг байгуулах нь” сэдэвт сургалт семинарт салбар зөвлөлийн гишүүдийн төлөөллийг оролцуулан ажлын туршлага судаллаа. Салбар зөвлөл 2010 оны ажлаа хэлэлцэн төлөвлөгдсөн ажлаа бүрэн биелүүлсэн гэж дүгнэсэн бөгөөд 2011 онд хийх ажлын төлөвлөгөөгөө батлуулаад байна.	90,0

99	Журам батлах тухай 2010.05.19 Дугаар 119	2. Тогтоолыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлж байхыг Сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Тогтоолыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээний хүрээнд 24 сумын Засаг даргын Тамгын газрын дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга нарт 2 өдрийн сургалт зохион байгуулсан. Монгол улсын Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоол болон “нийтээр дагаж мөрдөх шийдвэр” CD-г хүргүүлж, хэрэгжүүлж ажиллах талаар заавар, зөвлөмж өглөө. Энэ онд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон “Халаалтын улирлын хугацааг шинэчлэн тухай” 2010 оны 52 дугаар захирамж гарч улсын бүртгэлд бүртгүүлэн хуулийн нэгдсэн санд орлоо.	90,0
		5. Энэхүү тогтоолоор баталсан журмыг захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахдаа дагаж төрдөж ажиллахыг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Улсын Их хурлаас баталсан төрийн байгууллага, төрийн бус байгууллагын эрх бүхий албан тушаалтнуудад зөвлөсүгэй.	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрийг бүртгэх болсонтой холбогдуулан сумын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга нарт сургалт зохион байгуулж, тогтоолыг бүх сумдад хүргүүлэн хяналт тавин ажиллаж байна.	100,0
100	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 2010.10.06 дугаар 261	1.Засгийн газрын 2006 оны 64 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 2 дугаар үе шатны зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.	2010 онд байгууллагын архивын ажлын программ нэвтрүүлэх, төрийн архивын 2-р хадгаламжийн сангийн тавиурыг шинэчлэх тухай төлөвлөгөө, төсөвт тусгаж, байгууллагын архивын ажлын ORG-AMS программыг Мэргэжил сургалт үйлдвэрийн төвд нэвтрүүлэн туршиж байна. Архивын тасгийн ажилтнуудад хүчин чадал сайтай 2 компьютер олгож, 2-р хадгаламжийн санд 20 ширхэг төмөр тавиурыг 3,4 сая төгрөгөөр худалдан авч, дуу, дүрс бичлэг, фото зургийн баримтуудыг зориулалтын шүүгэнд хадгалж байна.	90,0
		2.Төрийн архивын мэдээлэл, эрэлт хайлтын автоматжуулсан нэгдсэн сан байгуулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор төрийн архивуудад гэрээгээр 175 операторч ажиллуулахад шаардагдах цалингийн сан болон тоног төхөөрөмжийн зардлыг 2011 оны 1 сарын 1-нээс эхлэн улсын төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг ХЗДХСайд Ц.Нямдорж, Сангийн Сайд С.Баярцогт, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	2011 онд Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөрийн эрчимжүүлэх зорилгоор хөтөлбөр хэрэгжих хугацаанд 6 ажилтанг гэрээгээр авч ажиллуулахаар төлөвлөөд байна.	70,0
101	Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох тухай 2010.09.15 дугаар 237	1.Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээг хавсралт ёсоор баталсугай.	Энэ тогтоолыг 2011 оны 01 дүгээр сарын 01-нээс мөрдөн ажиллаж байна.	100,0

		3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээг баталсан шийдвэрээ хүчингүй болсонд тооцохыг Засгийн газрын гишүүд, аймгийн Засаг дарга нарт даалгаж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд зөвлөсүгэй.	Энэ тогтоол гарсантай холбогдуулан улсын бүртгэлийн үйлчилгээний өмнө мөрдөж байсан хөлсний хэмжээг баталсан шийдвэрээ хүчингүй болголоо.	100,0
		Батлан хамгаалах		
102	Жагсаалт батлах тухай 2009.08.12 дугаар 246	1.Эмч багш нарыг цэргийн дүйцүүлэх алба хаасанд тооцох алслагдсан сумдын жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай. /Завхан аймгийн Асгат, Сантмаргац, Дөрвөлжин, Түдэвтэй, Ургамал, Завханмандал, Сонгино, Баянхайрхан, Тэс, Цэцэн-Уул/	Эдгээр сумдад ажиллаж байгаа, цэргийн алба хаах насны эмч, багш нарын судалгааг гаргахад 2009 оны байдлаар Асгатад 2, Баянтэсд 1, Баянхайрханд 1 хүн ажиллаж, эдгээр хүмүүстэй гэрээ байгуулаад байна.	100.0
103	Тооны дээд хязгаар, мөнгөн төлбөрийн хэмжээ тогтоох тухай 2010.03.24 дугаар 72	1.2010 онд цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэдийн тооны дээд хязгаарыг хавсралт ёсоор баталсугай.	2010 оны цэргийн албыг дүйцүүлэн хаалгахаар 64 иргэнийг бүртгэж, Засаг даргын захирамжаар баталгаажуулав.	100,0
		3.Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаагчдын мөнгөн төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч, ажиллахыг аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. 2.300.000 /хоёр сая гурван зуун мянган/	Аймгийн Засаг даргын захирамжаар 2010 онд 67 иргэнийг цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаахаар бүртгэж, 19,9 сая төгрөгийг дансанд төвлөрүүлэх арга хэмжээг зохион байгуулж байна.	100,0
Хоёр. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ				
		Үйлдвэр, худалдаа, хүнсний хангамж,		
1	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын тухай 2009.09.02 дугаар 56	1.2.Жижиг, дунд үйлдвэрийн бэлэн болсон төсөл шалгаруулах ажлыг шуурхай зохион байгуулан, зээл олгох асуудлыг хүндрэл багатай болгох талаар банктай тохиролцож, ажиллах үүргийг аймаг нийслэлийн дэд комисст өгч, уг ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авахыг аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангийн хөрөнгө оруулалтаар хөнгөлөлттэй зээл олгох дэд комиссыг аймгийн Засаг даргын захирамжаар шинэчлэн байгуулж, нийт 171 төсөл хүлээн авч, 105 төслийг шалгаруулан 958.0 сая төгрөгийн зээл олгохоор шийдвэрлэж, Шуудан банкинд шилжүүлсэн. Одоогийн байдлаар 81 төсөлд 780.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгоод байна. Тус хөтөлбөрийн хүрээнд 2009-2010 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлж байна. 2010 онд Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангийн хөнгөлөлттэй зээлд хамрагдахаар 3,0 орчим тэрбум төгрөгийн 196 төсөл ирүүлснийг аймгийн дэд комисс хянан шалгаж 808,0 сая төгрөгийн 86 төслийг Хадгаламж банкинд хүргүүлснээр 66 иргэн, аж ахуйн нэгжид 619,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгоод байна.Энэ хүрээнд 221 ажлын байр хадгалагдаж, шинээр 119 ажлын байр нэмэгдсэн байна.	100,0

2	Жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх, ядуурлыг бууруулах талаар авч байгаа арга хамжээний тухай 2009.12.16 дугаар 82	2.1."Нэг суурин-нэг бүтээгдэхүүн" хөдөлгөөнийг дэмжин хөгжүүлж, уламжлалт болон нутгийн бренд бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлж, нэр төрлийг нэмэгдүүлэх	Энэхүү тэмдэглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж байна. "Дэлхийн зөн" олон улсын байгууллагатай хамтран "Нэг байгууллага-нэг бүтээгдэхүүн" "Нэг бүлэг-нэг бүтээгдэхүүн" хөдөлгөөн өрнүүлж, сум, орон нутгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч байна. ЖДҮ-ийг дэмжих сангийн хөнгөлөлттэй зээлд бүх сумдыг хамруулах бодлого баримталж, нийт зээлийн 70-аад хувийг сумдын жижиг, дунд үйлдвэр эрхлэгч нарт хөнгөлөлттэй хэлбэрээр олгосон. Мөн тус хөтөлбөрийн хүрээнд 4 аж ахуйн нэгжид хүүгүй зээл олгох арга хэмжээ авсанаар "Мөнхөд мандаг" ХХК үйлдвэрлэлээ өргөжүүлэн хиамны үйлдвэрлэл, цех шинээр ажиллуулж, "Гарамгай нэгдмэл" ХХК цайны нэр төрлөө нэмэгдүүлэх боломж бүрдэж, нэрс, аньсны цай үйлдвэрлэж эхлээд байна.	90,0
		2.2.Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх болон ажилгүйдэл ядуурлыг бууруулах зорилгоор иргэд сайн дураараа хөрөнгө хөдөлмөрөөр нэгдэж, хоршин ажиллах нөхцлийг бий болгон тэргүүн ээлжинд дэмжиж ажиллах	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих санд хамрагдах үйлдвэрлэл эрхлэгчдийн төслийг дэд комисс хүлээн авч байна. 2009 онд энэ сангаас 81 төсөлд 780.0 сая төгрөг, үүнээс хоршоодод 63.6 сая төгрөг олгосон. Аймагт хоршоог хөгжүүлэх дэд хөтөлбөр батлан хэрэгжүүлж, аймгийн тэргүүний хоршоо шалгаруулах журам гарган ажиллаж байна. Одоо аймгийн хэмжээнд хөдөө аж ахуй, үйлдвэрлэл үйлчилгээний 164 хоршоо, хадгаламж зээлийн 40 хоршоо үйл ажиллагаа явуулж байна. Хоршоог хөгжүүлэх дэд хөтөлбөрийн хүрээнд 2010 онд зохион байгуулах ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн аймагт хоршоодын Нэгдсэн холбоог байгуулж, удирдлагыг холбогдох сургалт семинарт хамрууллаа.	90,0

		2.3.Мал аж ахуйн бүтээгдэхүүн, түүхий эдийг боловсруулах чиглэлийн жижиг, дунд үйлдвэрийг шинээр байгуулах замаар мал сүргийг эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашгийг нь дээшлүүлэх арга хэмжээ авах	Сартуул хонины ноосны бүтэц чанарыг шинжлүүлж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх судалгаа хийгдэж байна. Мах экспортлох болон малыг хөлөөр нь экспортод хөлөөр нь гаргах талаар ОХУ-ын Тува Улстай тохиролцох арга хэмжээ авч байна. Ноос, ноолуурыг гүн боловсруулах зорилтын хүрээнд аймагт “Завхан ноосны чадавхийн төв” ТББ 2010 оны 05 дугаар сард байгуулагдан, ноосны сургалт, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа болон ноосны лабораторийг ажиллуулж байна. Аймагт ноосны нэмүү өртгийн сүлжээ бий болгох, сүлжмэлийн 2 цех үйл ажиллагаа явуулж, сартуул хонины ноосон Брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэх эхлэл тавигдаж байна.	90,0
		2.4.Жижиг дунд үйлдвэрийн бүтээгдэхүүнийг сурагчдын үдийн хоол, ахмад настны асрамж, сувилал болон үйлчилгээнд зориулан худалдан авах зэргээр борлуулалтад нь дэмжлэг үзүүлж ажиллах	Аймгийн хэмжээнд 25 талх нарийн боовны үйлдвэрлэл эрхлэгчид, сүү цагаан идээний “Миний тулга” ХК-иуд сурагчдын үдийн цайнд бүтээгдэхүүнээ нийлүүлж байна.	90,0
3	Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай 2010.05.05 дугаар 113	“Хөрөнгө гаргах тухай” Засгийн газрын 2010 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 57 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “аймаг, нийслэлд хуваарилах буудайн хэмжээ”-г хавсралт ёсоор өөрчилсүгэй.	Манай аймагт хуваарилагдсан 2000,0 тн халтар арвайн буудайнаас 1036 тонныг орон нутагт татан авч, үлдсэн тэжээлийг нөөцөд үлдээхээр шийдвэрлэсэн.	100,0
		Дэд бүтэц, барилга, хот байгуулалт		
4	Завхан, Говь-Алтай аймгийн эрчим хүчний хангамжийн тухай 2009.10.7 дугаар 63	1.Завхан, Говь-Алтай аймгийн хэрэглэгчдийг эрчим хүчээр найдвартай хангах бодлогоо оновчтой тодохойлон түүнийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын арга, хэлбэрийн талаар санал боловсруулан ойрын хугацаанд Засгийн газарт оруулахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригтод даалгав.	Завхан, Говь-Алтай аймгийн хэрэглэгчдийг эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангахад зориулж, Могойн голын уурхайд Дулааны цахилгаан станц барих шав тавигдсан . Энэхүү томоохон бүтээн байгуулалтын ажил болох Дулааны станц ашиглалтанд орсоноор Завхан, Говь-Алтай, Хөвсгөл аймгуудын эрчим хүчний асуудал бүрэн шийдэгдэж 2011 оны 11 сарын 11-нд ашиглалтанд оруулахаар төлөвлөөд байсан боловч энэ асуудал тодорхой хугацаагаар хойшлоход хүрээд байна. Энэ нь уг станцыг Завхан аймгийн нутагт шилжүүлэн байршуулахтай холбоотой боловч одоогоор Засгийн газрын шийд гараагүй байна.	100.0
5	Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2010 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний явцын тухай 2010.01.20 дугаар 5	5а.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасны дагуу 2010 оны 2 дугаар сарын 1-ний дотор улсын хэмжээнд бүх тендерийг зарлаж, 4 дүгээр сарын 1-ний дотор тендер шалгаруулалтыг дүгнэж дуусган гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажлыг нь эхлүүлсэн байх	Боловсролын сайдаас орон нутагт эрх шилжиж ирэх ажлууд оройтож, 3 дугаар сард ирснээс болж, тендер шалгаруулах ажил хугацаа хоцорсон боловч бүх ажлууд хуулийн дагуу хийгдэж дууссан.	100,0

		5б.Тендер шалгаруулалтын үнэлгээг богино хугацаанд буюу 14 хоногт багтаан хийж, дуусган гэрээ байгуулах зөвлөмжийг гаргах, тендер шалгаруулалтын онцгой журам болох харьцуултын болон гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэхдээ хууль зөрчихгүй байх, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.1.1-д заасан босго үнээс өндөр төсөвт өртөгтэй аливаа худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын журмын дагуу зохион байгуулах	Аймгийн хэмжээнд худалдан авах ажиллагаа холбогдох хууль журмын дагуу явагдаж дуусан. Ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.1.1-д заасан босгох үнийг баримтлан бүх тендер шалгаруулалтын ажлуудыг хуулийн дагуу хийж гүйцэтгэсэн.	100,0
		5в.Тендерийн урилга, үр дүнг өдөр тутмын 2 сонинд нийтэлж, Засгийн газрын Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим сүлжээнд /www.e-procurement.mn/ тавьж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэлийг олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлж байх	Хуулийн 8.1.1-д заасан босго үнээс өндөр төсөвт өртөгтэй ажлыг цахим сүлжээ болон өдөр тутмын Зууны мэдээ, Өдрийн сонин, орон нутгийн телевиз, “Завхан сонин”, Сангийн Яамны болон аймгийн ВЕБ сайтад тавьж олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэн хуулийн дагуу гүйцэтгэгчийг шалгаруулсан.	100,0
6	Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2009 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хийсэн үнэлгээний дүн, худалдан авах ажиллагааны 2010 оны төлөвлөгөөний тухай 2010.04.14 дугаар 22	4.3. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн худалдан авах ажиллагаанд хууль тогтоомж мөрдүүлэх, зөрчил гаргасан албан тушаалтан, байгууллагад хариуцлага тооцох, эдгээр аж ахуйн нэгжийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан болон хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаархи мэдээллийг хуульд заасны дагуу Сангийн яаманд тайлагнаж ажиллахыг Төрийн өмчийн хороо /Д.Сугар/, аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов	2008-2010 оны худалдан авах ажиллагааны тайланг хуульд заасны дагуу тогтоосон хугацаанд Сангийн яаманд тогтмол хүргүүлэн ажиллаж байна. 2009 оны худалдан авах ажиллагааны тайлангийн дагуу Сангийн Яамнаас 78.5 хувийн үнэлгээ өгсөн.	100.0
7	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны 2010 оны 1-р улирлын явц, үр дүнгийн тухай 2010.05.12 дугаар 27	2.1. Төсвийн Ерөнхийлөн захирагч нараас аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт шилжүүлсэн болон зураг, төсөл хийгдээгүйн улмаас тендер шалгаруулалтын хугацаа хоцорч байгаа төсөл, арга хэмжээний худалдан авах үйл ажиллагааг 2010 оны 6 дугаар сарын 01-ний дотор холбогдох журмын дагуу шалгаруулж, гэрээ байгуулан ажлыг нь эхлүүлэх	Зураг төсөл хийгдээгүйн улмаас Боловсролын сайдын багцаас 1 ажил хугацаа хоцорсон.Бусад ажлууд хугацаандаа ажил гүйцэтгэх гэрээний дагуу хийгдэж дууссан.	100,0
		2.2. Худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн албан хаагчдыг давтан сургалтад хамруулах, мэргэшүүлэх, тэдний үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх арга хэмжээ авах	Худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан мэргэжилтэнг Сангийн яамнаас зохион байгуулсан 2 удаагийн сургалтанд хамруулж мэргэжилийг дээшлүүлж, орон нутагт Сангийн Яамны мэргэжилтнүүдийн тусламжтайгаар 2010 онд орон нутгийн мэргэжилтнүүдийн сургалтыг зохион байгуулж, хариуцлагыг өндөржүүлэх арга хэмжээ авч байна.	100.0

8	Могойн голын нүүрсний уурхайг түшиглэж барих дулааны цахилгаан станцын ажлын явцын тухай 2010.05.26 дугаар 30	5.1. Завхан, Говь-Алтай аймгийн хэрэглэгчдийг эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангах зорилгоор Могойн голын нүүрсний уурхайг түшиглэж дулааны цахилгаан станц барихдаа хүчин чадлыг хэрэглээтэй нь уялдуулан тодотгох, барих, ашиглах, шилжүүлэх хэлбэрийг баримтлах, шилжүүлэх хугацааг багасгах чиглэлээр хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийж Концессын тухай хуульд нийцүүлэн гэрээг шинэчлэн байгуулах боломжийг судлан Засгийн газрын хуралдаанд ойрын хугацаанд танилцуулахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригтод даалгав.	Завхан, Говь-Алтай аймгийн хэрэглэгчдийг эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангах зорилгоор Могойн голын нүүрсний уурхайг түшиглэж дулааны цахилгаан станц барих ажлын зураг төсөл, техникийн нөхцөл, эдийн засгийн үндэслэл бэлэн болж, байгууламжийн шав тавих арга хэмжээ хийгдсэн.	100.0
9	“Мэдээлэл, холбооны нэгдсэн сүлжээний шинэчлэл” төслийн тухай 2010.05.26 дугаар 30	7.2.а. Мэдээлэл, харилцаа холбооны болон шинэ техник, технологи нэвтрүүлэхтэй холбоотой төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ Тагнуулын ерөнхий газар, Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын саналыг урьдчилан авч байх	Дээрхи тэмдэглэлийг хяналтанд авч, холбогдох газруудад хувилан хүргүүлж, мөрдөн ажиллаж байна.	100,0
		7.2.б. үзэл баримтлал, бодлого чиглэл нь тодорхой болоогүй болон маргаантай байгаа асуудлыг Засгийн газрын хуралдаанд зохих журмын дагуу танилцуулсны үндсэн дээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлж байх	Тэмдэглэлийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч байна.	100,0
Хөдөө аж ахуй				
10	Өвөлжилтийн байдал хүндэрч байгаатай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2010.01.11 дугаар 3	7.Өвөлжилийн нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан бүх шатны Засаг дарга нарыг гадаад, дотоодод томилолтоор ажиллуулахыг зогсоож, гамшгийн нөхцөл байдалтай холбогдуулан тэдгээрийг удирдлагаар хангаж, хариуцлагыг өндөржүүлэн ажиллахыг ...аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Сумдын Засаг дарга нар болон төсвийн байгууллагын удирдлагуудыг аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын даргын зөвшөөрлөөр гадаад, дотоодод томилолтоор ажиллуулж байхаар шийдвэрлэж хэрэгжүүлж байна.	100,0
11	Мал өвөлжилтийн байдал хүндэрсэн зарим аймагт Улсын онцгой комиссын шийдвэрийн дагуу томилогдон ажилласан ажлын хэсгийн дүгнэлтийн тухай 2010.2.3 дугаар 9	Мал өвөлжилтийн байдал хүндэрсэн зарим аймагт Улсын онцгой комиссын шийдвэрийн дагуу томилогдон ажилласан ажлын хэсэг Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Говь-Алтай, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Увс, Төв, Ховд, Хөвсгөл аймгийн 65 сум гамшгийн байдлын зэрэглэлд, 68 сум зудын зэрэглэлд байна гэсэн дүгнэлт гаргасныг танилцуулав.	Манай аймгаас 8 сум гамшгийн, 5 сум зудын, 6 сум зудархуу зэрэглэлд өвөлжиж хаваржсан. Эдгээр сумдад өвс, тэжээл, бусад тусламжийг харгалзан хуваарилж, сумдаас тавьсан 47 асуудалд холбогдох арга хэмжээг авч ажиллаа.	100,0
12	Мал аж ахуйн салбарын 2010-2011 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай 2010.07.07 дугаар 40	2.Хадлангийн талбайгүй зарим аймаг, сум, аж ахуйн нэгжийг боллоцоотой аймаг, сумын нутагт хадлан бэлтгүүлэх замаар нөөцлөх өвсний хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг ЗТБХБ-ын Сайд, ХХААХҮСайд, аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	Тус аймгийн 24 сум өөрийн аймгийн нутагтаа хадлан, тэжээлээ бэлтгэсэн бөгөөд Ургамал, Дөрвөлжин, Сантмаргаз сумууд өөр сумын нутагт хадлан бэлтгэж авсан болно.	100,0

13	Мал амьтны гоц халдварт шүлхий өвчний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2010.09.17 дугаар 49	5.Баруун бүсийн аймгуудыг малын гоц халдварт шүлхий өвчний вакцин хэрэглэдэггүй, эрүүл бүс нутгийн статустай болгох зорилгоор Булган, Архангай, Өвөрхангай, Өмнөговь аймагтай зэргэлдээ Хөвсгөл, Завхан, Баянхонгор аймгуудын хилийн заагийн дагуу мал эмнэлгийн хяналтын пост байгуулах арга хэмжээ авахыг ХХААХҮСайд Т.Бадамжунайд даалгав гэжээ	Их-уул, Отгон сумын мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгжүүдэд гоц халдварт өвчний тандалт хийлгэж байгаа бөгөөд одоогийн байдлаар малын өвчлөл гараагүй байна.	100,0
14	Монгол улсын Ерөнхий Сайд орон нутагт ажиллах тухай 2010.07.14 дугаар 41	6.Архангай, Хөвсгөл, Увс, Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Завхан, Баянхонгор, Өвөрхангай аймгийн зарим сумдын Засаг даргын Тамгын газарт суудлын автомашин авах болон бусад зардалд шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх тухай Засгийн газрын тогтоол гаргахаар болов гэжээ	Энэхүү тэмдэглэлтэй танилцан хяналтанд авлаа.	100,0
15	Монгол улсын Ерөнхий Сайд С.Батболд зарим аймгуудад ажилласан дүнгийн тухай 2010.08.18 дугаар 44	3.1. “Мал аж ахуйн салбарын 2010-2011 он өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2010 оны 66 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, хадлан, тэжээл бэлтгэх ажлыг үр дүнтэй шуурхай зохион байгуулахыг ХХААХҮСайд Т.Бадамжунай, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Хадлан бэлтгэх ажилд хяналт тавих ажлын хэсгийг байгуулж ажилласнаар энэ онд хадлан 17,1 мянган, ногоон тэжээл 2,6 мянган тонныг бэлтгэсэн нь өмнөх оныхоос өвс 6,7 мянган тонн, ногоон тэжээл 4 дахин илүү байна. Аймгийн нөөцөд 400 тонн, сумын нөөцөд 1174 тонн өвс тэжээлийг бэлтгэсэн болно.	90,0
		3.3. Иргэний шинэчилсэн бүртгэлийг орон даяар зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулах бэлтгэл ажлыг ханган, улсын бүртгэлийн болон холбогдох бусад байгууллагад дэмжлэг үзүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Иргэний шинэчилсэн бүртгэлийг аймгийн хэмжээнд амжилттай хийх зорилгоор аймгийн Засаг даргын 24 тоот захирамж гарч уг ажлын бэлтгэлийг хангах, зохион байгуулалтыг удирдан зохицуулах үүрэг бүхий аймаг, сумын ажлын хэсгийг Засаг даргын Тамгын газрын дарга нараар ахлуулан ажиллуулж, зохих үр дүнд хүрсэн болно. Иргэний шинэчилсэн бүртгэлд 16 ба түүнээс дээш насны 44.4 мянган хүн хамрагдсан нь Статистик мэдээгээр авсан бүртгэлд хамрагдвал зохих 51.1 мянган хүний 86.8 хувь, сумдаас авсан бүртгэлд хамрагдвал зохих бодит хүмүүсийн 95.5 хувь нь хамрагдаад байна. Манай аймагт Иргэний шинэчилсэн бүртгэлийн ажил улсын дунджийн түвшинд явагдаж байна.	90,0

		4.Засгийн газрын бодлого, шийдвэрийг иргэдэд ойлгомжтой хэлбэрээр тайлбарлан сурталчлах ажлыг үр дүнтэй, шуурхай зохион байгуулж байхыг Монгол улсын Сайд, ЗГХЭГ-ын дарга Ч.Хүрэлбаатар, аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгав” гэжээ	Засгийн газрын болон аймаг орон нутгийнхаа бодлого, шийдвэрийг иргэдэд сурталчлах зорилгоор цаг үеийн ажлын мэдээ, мэдээллийг аймгийн веб сайтанд байрлуулж, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэслээр тогтмол сурталчлан төрийн байгууллагуудын ажлын үр дүнг сайжруулах, иргэд олон нийтийн идэвхи санаачлагыг өрнүүлэхэд ихээхэн анхаарч багагүй зүйлийг хийж, цаашид хийхээр төлөвлөн үйл ажиллагаагаа явуулж байна.	100,0
		5. “Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай судалж, тодорхой хариуг хуулиар тогтоосон хугацаанд өгч байхыг сайд, аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгав” гэжээ	2010 онд аймгийн Засаг дарга болон түүний Тамгын газарт 364, нутгийн захиргааны байгууллагад 6392 өргөдөл, гомдол ирсэнийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хугацаанд нь барагдуулж хариу өглөө. Аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлсэн нийт өргөдлийн 12,8 хувь нь тусламж хүссэн, 27,1 хувь нь ажил хүссэн, 60 хувь нь бусад асуудлыг шийдвэрлүүлэхээр ирүүлсэн өргөдөл байна. Өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэхдээ тухай бүр дүгнэлт гарган хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, хуулийн хугацаанд хариу өгч ажиллаа.	100,0
16	2010-2011 оны мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангасан дүнгийн тухай 2010.11.23 дугаар 60	2,3. Аймаг, нийслэл, сум дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөц нэмж бүрдүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Архангай, Булган, Говь-Алтай, Дархан-уул, Дорноговь, Дорнод, Завхан аймгийн болон нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Сумдаас авах өвс, тэжээлийн захиалгыг авахын зэрэгцээ иргэд, аж ахуйн нэгжүүдээс худалдах өвс, тэжээлийн тоо хэмжээг авч хооронд нь зохицуулах арга хэмжээг авч байна.	70,0
		Хууль хяналт		

17	Өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг бууруулах тухай 2009.12.2 дугаар 76	2.Нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохиогдож байгаа олон нийтийг хамарсан арга хэмжээ болон нийтийн хоол, баар, рестораны үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт даалгав.	2010 онд Хууль зүйн хэлтэс, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зохицуулах зөвлөл, Мэргэжлийн хяналтын газар, Улиастай сум, Стандартчлал хэмжил зүйн хэлтэстэй хамтран олон нийтийг хамарсан арга хэмжээ болон нийтийн хоол, баар ресторануудын үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг цэг салбаруудад хяналт шалгалт хийлээ. Шалгалтанд нийтдээ зоогийн газар 3, кафе 7, дэргүүр 62 хамрагдсанаас захиргааны 7 зөрчил илэрч холбогдох албан хаагчид арга хэмжээг газар дээр нь авч, анхааруулга, санамж өгч ажиллаа. Мөн Хууль зүйн хэлтэс Цагдаагийн газрын хэв журмын тасагтай хамтарсан “Урт гар” хэсэгчилсэн шалгалтыг Улиастай сумын пост, нийтийн үйлчилгээний газрууд, ТТАЗСЗ-тэй хамтран “Онцгой объектуудын харуул хамгаалалт” нэгдсэн хяналт шалгалтыг усан хангамжийн газар болон бусад онцгой объектуудад хийгээд байна.	100.0
----	--	---	--	-------

18	Улсын үзлэгийн дүн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2009.12.23 дугаар 84	1.3.2009 оны архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагуудын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгээр илэрсэн зөрчлийг бүрэн арилгах арга хэмжээ авч ажиллахыг улсын үзлэгт хамрагдсан байгууллагуудын удирдлагад даалгав.	2009 оны архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагуудын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгээр аймгийн дүнгээр 89.2 оноо авч “В” үнэлгээтэй дүгнэгдсэн. Мэдээллийн технологийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай төлөвлөгөө гаргаж мөрдөн ажиллаж байна. Тухайлбал: Албан хэрэг хөтлөлт, архивын программыг нэвтрүүлэх, дотоод сүлжээ, веб сайтыг шинэчилж, архивын сан хөмрөгийн хадгалалт хамгаалалтыг сайжрууллаа. Архив, бичиг хэргийн ажилтнуудыг мэргэшүүлэх давтан сургах сургалтад 2010 онд 19 хүнийг хамрууллаа. Архивын баримтын хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, байгууллага бүр архив хадгалах өрөө байр гаргаж тохижуулан, архивын баримтаа эмхлэн цэгцэлж, тоо бүртгэлд оруулан, байгууллагын архивт хадгалах хугацаа дууссан 53 байгууллагын 1397 хадгаламжийн нэгж баримтыг татан авч нөхөн бүрдүүлэлт хийлээ. Монгол улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 27 дугаар тушаалаар батлагдсан комисс Архивын тасгийн үйл ажиллагаанд Улсын үзлэг хийлээ. Улсын үзлэгээр төрийн архивын үндсэн үйл ажиллагааг 9 үзүүлэлт 50 аргачлалаар дүгнэхэд 902 оноо, 90.2 хувиар аймгийн архивын ажил А буюу маш сайн дүн авлаа. Архивын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт тус аймагт хангалттай сайн зохион байгуулагдаж байна гэсэн дүгнэлт өглөө.	100,0
----	--	---	---	-------

19	<p>“Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн тухай 2010.04.07 дугаар 21</p>	<p>1.1. Улсын Их Хурлын 2003 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилт хангалтгүй байгаад дүгнэлт хийж эрхэлсэн ажлын хүрээ, нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд уг хөтөлбөрийн үндсэн чиглэл, зарчимд нийцүүлэн нарийвчилсан төлөвлөгөө гарган ажиллахыг сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.</p>	<p>Хууль зүйн хэлтсээс санаачлан “Архидалтын эсрэг хамтдаа” зөвлөгөөнийг зохион байгууллаа. Зөвлөгөөнд 25 байгууллагын удирдах болон бодлого хэрэгжүүлэх чиглэлийн удирдах албан тушаалтанууд оролцсон. Зөвлөгөөнд аймгийн Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Шүүх, Нэгдсэн эмнэлэг, ГХУСЗЗ, Өмгөөлөгчдийн зөвлөлөөс архидан согтуурлын өнөөгийн нөхцөл байдал, шалтгааныг тодорхойлж, түүнээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга замыг тусгасан илтгэлүүд хэлэлцүүлээ. Зөвлөгөөний үр дүнд аймгийн хэмжээнд Засаг даргын албан даалгавар гаргуулж, ажлын хэсэг байгуулан төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Архидан согтуурахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн биелэлтийг хангуулах зорилгоор Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Мэргэжлийн хяналтын газар, Улиастай сумын ЗДТГ, Хууль зүйн хэлтэс, Стандартчлал хэмжил зүйн хэлтэс хамтран Архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг цэг салбаруудад хамтарсан хяналт шалгалт хийлээ. Мөн шалгалтын үр дүнг хангуулах зорилгоор аймгийн Засаг даргын “Архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, хууль сурталчлах аян зохион байгуулах тухай” 2010 оны 153 дугаар захирамж гарган аймгийн хэмжээнд “Архидалтгүй-Эрүүл амьдрал” 2 сарын аян зохион байгуулаад байна. Аяны хүрээнд архидан согтуурахтай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагууд 7 хоног бүрээр төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Энэ арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан нэг томоохон ажил нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн 43 байгууллагаар 3 хоноогоор ээлжлэн аяны тууз аялуулсан явдал юм.</p>	90,0
----	---	---	---	------

20	<p>“Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг 2009 оны төлөвлөгөөний хрэгжилтийн тухай 2010.04.07 дугаар 21</p>	<p>4.1. “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг байгууллагынхаа онцлогт тохируулан судалгааны үндсэн дээр бодитой төлөвлөж, тэдгээрийг хэрэгжүүлэх талаар удирдлагын манлайллыг сайжруулах</p>	<p>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд төрийн байгууллагын дарга эрхлэгч, хүний нөөцийн мэргэжилтнүүдийг оролцуулан “Авлигын эсрэг хамтарсан уулзалт” зохион байгууллаа . Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн хурлын 2010 оны 30 дугаар тогтоолоор Авлигын эсрэг хамтарсан баг байгуулан ажиллаж байна. Мөн аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Авлига хариуцсан мэргэжилтэн нар “Шударга ёсны төлөө 2010” аяны хүрээнд зохион байгуулагдсан сургалт семинарт оролцож, сургалтын үр дүнд төрийн байгууллага дахь авлига, хүнд суртлын талаархи иргэд, иргэний нийгмийн байгууллагын төсөөллийг тодорхойлох зорилгоор “ЗАВХАН” орон нутгийн олон нийтийн телевизтэй хамтран “Шударга ёсны төлөө хамтдаа” теле нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт аймгийн ЗДТГ-ын дарга, Шүүх, Прокурор, Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Улиастай хотын Захирагч, Тагнуулын хэлтэс, Боловсрол соёлын газрын дарга, төрийн бус байгууллагыг төлөөлж аймгийн өмгөөлөгчдийн холбоо, Эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагын сүлжээ, Үйлдвэрчний эвлэл, Ахмадын хороо, Залуучуудын холбооны дарга нар болон иргэдийн төлөөлөл оролцлоо. Шударга ёсны тухай иргэдийн ойлголтын талаархи нэвтрүүлгийг зөвлөгөөнд оролцогчдод үзүүлэн хэлэлцүүлэг өрнүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай, хүнд суртал чирэгдэлгүй хүргэх боломж нөхцлийн талаар төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл харилцан саналаа солилцлоо.</p>	90,0
		<p>4.2. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих, тайлагнах асуудлыг эрчимжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах</p>	<p>Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсээс 2010 онд Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргагч нарт зориулан бүх сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, аймгийн Цагдаагийн албан хаагчид, сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, нарийн бичгийн дарга нар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний ажилтнууд зэрэг нийт 100 гаруй алба хаагчдад 20 цагийн сургалтыг зохион байгууллаа.</p>	90,0

		4.3. Салбарын хэмжээний болон эрхлэх ажлынхаа хүрээний байгууллагуудын авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр үнэлж дүгнэн, нэгдсэн тайланг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлэх	Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр гаргаж, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлж байна. Мөн 2010 онд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн биелэлтийг хөтөлбөр хэрэгжсэн хугацаагаар, Авлигын эсрэг хамтарсан 3 талт гэрээний биелэлтийг бүтэн жилээр гарган Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.	100,0
